



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫН  
2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

## Улаанбаатар хот

2026 он

### АГУУЛГА

|                                                                                                        |    |
|--------------------------------------------------------------------------------------------------------|----|
| МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....                                    | 3  |
| МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ .....                                                    | 4  |
| 1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ .....                                                                    | 10 |
| 1.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого .....                                                         | 12 |
| 1.2. Нэгдсэн төсвийн зарлага .....                                                                     | 13 |
| 1.3. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр.....                                             | 15 |
| 1.4. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал.....                                                    | 17 |
| 1.5. Татварын зарлага .....                                                                            | 19 |
| 1.6. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээ .....                                                        | 20 |
| 1.7. Нэмэлт төсөв .....                                                                                | 44 |
| 1.8. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ, ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН..... | 45 |
| 2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ.....                                                                             | 46 |
| 2.1. Улсын төсвийн орлого .....                                                                        | 46 |
| 2.2. Улсын төсвийн зарлага.....                                                                        | 48 |
| 2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт .....                                                              | 59 |
| 1. ДНБ ба төсвийн хөрөнгө оруулалт .....                                                               | 59 |
| 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, 2020-2025 он.....                                                   | 60 |
| 3. Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /бүсээр/.....                                                  | 62 |
| 4. төсвийн хөрөнгө оруулалтад хэмнэлт .....                                                            | 62 |
| 2.4. Засгийн газрын нөөц сан .....                                                                     | 72 |
| 3. ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН.....                                                                          | 73 |
| 4. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН.....                                                                   | 75 |
| 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ .....                                                         | 76 |
| 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ .....                                                              | 77 |
| 7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ.....                                                                             | 78 |
| 8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР .....                                                                             | 80 |
| ДОТООД ҮНЭТ ЦААС .....                                                                                 | 82 |
| 8.1. ГАДААД ҮНЭТ ЦААС.....                                                                             | 84 |
| 8.2. ГАДААД ЗЭЭЛ .....                                                                                 | 85 |
| 8.3. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА .....                                                               | 86 |
| 8.4. ОРОН НУТГИЙН ЗЭЭЛЛЭГ .....                                                                        | 87 |
| 8.5. ДАМЖУУЛАН ЗЭЭЛ .....                                                                              | 88 |



## МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гарган, танилцуулж байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвийн 36 ерөнхийлөн захирагч, нийслэл, аймаг, дүүргийн 5,577 төсөвт байгууллагууд, Үндэсний баялгийн сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангуудын төсвийн гүйцэтгэл хамрагдсан болно.

Түүнчлэн Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын зарлагын тайлан, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүнгийн танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл зэргийг нэгтгэн танилцуулж байна.

### **Төсөв, эдийн засгийн голлох үзүүлэлтүүд 2025 онд:**

- Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2025 онд 33,179.2 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,027.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.
- Төсвийн тогтворжуулалтын санд 562.5 тэрбум, Хуримтлалын санд 602.9 тэрбум, Ирээдүйн өв санд 1,710.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна.



## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

**Эдийн засгийн өсөлт.** 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр дотоодын нийт бүтээгдэхүүн 89.9 их наяд төгрөгт хүрч, эдийн засаг 6.8 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд худалдаа болон үйлчилгээний зарим салбараас бусад эдийн засгийн салбаруудын өсөлт эергээр нөлөөллөө.

### Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт салбараар (нэгж хувь)

|                            | 2021       | 2022       | 2023       | 2024       | 2025*      |
|----------------------------|------------|------------|------------|------------|------------|
| <b>Эдийн засгийн өсөлт</b> | <b>1.6</b> | <b>5.0</b> | <b>7.4</b> | <b>5.1</b> | <b>6.8</b> |
| Хөдөө аж ахуй              | -0.8       | 1.7        | -1.3       | -3.6       | 2.9        |
| Үйлдвэрлэл                 | -0.6       | -1.2       | 3.2        | 1.6        | 2.9        |
| Уул уурхай                 | 0.1        | -2.1       | 2.6        | 1.4        | 1.4        |
| Боловсруулах               | -0.1       | 0.5        | 0.4        | -0.3       | 0.7        |
| Цахилгаан, ус              | 0.2        | 0.1        | 0.1        | 0.1        | 0.2        |
| Барилга                    | -0.9       | 0.2        | 0.1        | 0.4        | 0.5        |
| Үйлчилгээ                  | 1.8        | 3.2        | 4.7        | 5.4        | 1.0        |
| Худалдаа                   | 0.6        | 1.1        | 0.8        | 1.4        | -0.6       |
| Тээвэр                     | -0.3       | 0.4        | 1.8        | 1.0        | 0.3        |
| Бусад                      | 1.5        | 1.7        | 2.1        | 3.0        | 1.3        |
| Цэвэр татвар               | 1.3        | 1.4        | 0.8        | 1.8        | 0.0        |

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо\* урьдчилсан гүйцэтгэл

Уул уурхайн салбарын өсөлт жилийн хоёрдугаар хагаст сэргэснээр 10.6 хувьд хүрч, нийт эдийн засгийн өсөлтийн 1.4 хувийг бүрдүүлэв. Уул уурхайн салбар оны эхний хагаст 1.1 хувийн өсөлттэй байсан бол нүүрсний экспортын хэмжээ нэмэгдсэнээр сэргэж 4 дүгээр улиралд 95.5 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өслөө. Түүнчлэн зэсийн баяжмал үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 36 хувиар, тухайлбал, Оюу толгойн гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр оны эхний гурван улиралд 42.2 хувиар өссөн нь уул уурхайн салбарын өсөлтийг дэмжив. Мөн төмрийн хүдрийн үйлдвэрлэлийн өсөлт хадгалагдаж 8.8 сая тоннд хүрснээр өмнөх оны мөн үеэс 31.8 хувиар өслөө. Алтны олборлолт 11 улирал дараалан буурч байснаас сэргэж 2025 оны 4 дүгээр улиралд 13.1 тоннд хүрч, 4.1 хувиар өсөв. Харин газрын тос олборлолт 8 улирал дараалан буурч 3.8 сая тонн болсноор уул уурхайн салбарын өсөлтийг сааруулсан байна.

Хөдөө аж ахуйн салбар 33.2 хувиар өсөж нийт эдийн засгийн өсөлтийн 2.9 хувийг бүрдүүллээ. Бойжсон төлийн тоо толгой 21.7 саяд хүрч (төл бойжилт 96.5 хувь) өмнөх оны мөн үеэс 5.5 сая толгой малаар нэмэгдэж, том малын зүй бус хорогдол 359 мянга болж, өмнөх оны мөн үеэс 9 сая толгой малаар буурснаар хөдөө аж ахуйн салбарын 90 орчим хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн салбарын өсөлт өндөр гарлаа. Харин газар тариалангийн салбарын хувьд оны эхний хагаст тариалангийн гол бүс нутгаар олон жилийн дунджаас бага хур тунадас унаснаар нийт хураасан үр тариа өмнөх оноос 148.6 мянган тонн, төмс 137.3 мянган тонн, хүнсний ногоо 42.5 мянган тонн, тэжээлийн ургамал 61 мянган тонноор тус тус буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын өсөлт эрчимжлээ. Боловсруулах салбарын өсөлт эрчимжиж, 2025 онд 10 хувиар өслөө. Үүнд төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн

бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл боловсруулах салбарын өсөлтийг голлон дэмжсэн байна. Эрчим хүчний салбар 2025 онд 10.2 хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийн 0.2 нэгж хувийг бүрдүүлэв. Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 9.6 тэрбум кВт цагт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар, дулааны эрчим хүч үйлдвэрлэл 17.3 сая Гкал-д хүрч, 8.5 хувиар нэмэгдэн эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн өсөлт тогтвортой хадгалагдлаа. Үүнд, шинээр ашиглалтад орсон Тосон, Бөөрөлжүүт зэрэг ДЦС-уудын үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөллөө. Барилгын салбарын өсөлтийг Улаанбаатар хот дахь эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламж болон Багахангай-Хөшгийн хөндий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлууд, Сэлэнгэ аймаг дахь 70 МВт хүчин чадал бүхий дулааны цахилгаан станц, Дорнод аймгийн авто замын бүтээн байгуулалтын ажлууд зэрэг нь үргэлжлүүлэн тэтгэснээр 2025 онд 15.9 хувиар өслөө.

Тээврийн салбар 2025 онд 4.8 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 0.3 нэгж хувийг бүрдүүлэв. Зам, тээврийн салбар 2025 онд бүх төрлийн тээврээр нийт 146.4 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос 10.3 хувиар нэмэгдсэн бөгөөд төмөр замын ачаа тээвэр 50 сая тоннд хүрч 8.7 хувиар, авто замын ачаа тээвэр 96.5 сая тоннд хүрч 10 хувиар, агаарын тээврийн ачаа 12.5 мянган тоннд хүрч 20 хувиар тус тус нэмэгдсэн нь өсөлтөд нөлөөллөө. Нийт ачаа тээврийн 65.9 хувийг авто тээвэр, 34.1 хувийг төмөр замын тээвэр, 0.01 хувийг агаарын тээврийн ачаа эзэлж байна.

#### **Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт:**

Инфляц 2025 оны дунджаар 8.6 хувь, оны эцэст 7.5 хувь гарсан байна. 2025 оны эхний улиралд эрэлтийн гаралтай инфляц өндөр хэвээр хадгалагдаж, инфляцыг голлон тайлбарлаж байсан бол 2 дугаар улирлаас эхлэн аажмаар саарсан байна. Эрэлтийн инфляц саарахад 2025 оны төсөвт тодотгол хийж, төсвийн урсгал зардлыг бууруулсан, ханшийн зах зээл тогтворжсон, хэрэглээний зээлд зохицуулалт хийсэн, бодлогын хүүг 12 хувьд хадгалсан зэрэг бодлогын арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн нь голлон нөлөөллөө. Харин нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлт оны сүүлийн хагаст хүнсний үнийн өсөлтөөс үүдэлтэйгээр эрчимжсэн байна. Тухайлбал, махны үнэ улирлын хандлагаар буураагүй, 2025 оны зун ган болж ургац алдсанаар хүнсний ногооны нийлүүлэлт багасаж, үнэ өссөн нь нөлөөлсөн байна.

Төв банкнаас 2025 оны 3 дугаар сард мөнгөний бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 12 хувьд хүргэсэн байна. Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл 2025 оны эцэст 43.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19 хувиар өсөж, өсөлтийн хурд өмнөх онтой харьцуулахад 16.5 нэгж хувиар саарсан байна. Зээлийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, тэтгэврийн зээл болон барилгын салбарын зээл голлон нөлөөлсөн байна. Мөнгөний нийлүүлэлт 2025 оны эцэст 47.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өслөө. Эх үүсвэр бүтцээр авч үзвэл, төгрөгийн хадгаламж мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 9.4 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 2.1 нэгж хувийг

гадаад валютын харилцах, 0.2 нэгж хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлсэн бол төгрөгийн харилцах -1.1 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлжээ. Байршуулалт талаас авч үзвэл, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг дотоод цэвэр активын өсөлт голчлон бүрдүүлж байна.

## Зураг 1. Инфляц, мөнгөний нийлүүлэлт, зээлийн үлдэгдэл

### 1. Инфляц

(хувь)



Эх сурвалж: ҮСХ


### 2. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт пассив тал (хувь)



Эх сурвалж: Монголбанк

### 3. Зээлийн үлдэгдлийн өсөлт

(хувь)



Эх сурвалж: Монголбанк

## Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин.

### 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл:<sup>1</sup>

Эдийн засгийн идэвхжил хадгалагдсан хэдий ч хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд 2025 онд өмнөх онтой харьцуулахад харьцангуй тогтвортой түвшинд байна. Нийт ажиллагчдын тоо өмнөх оноос 3.3 мянган хүнээр буюу 0.2 хувиар нэмэгдэж, 1 сая 359 мянгад хүрсэн нь ажил эрхлэлт огцом тэлээгүй боловч өсөлтөө хадгалсныг харуулж байна.


<sup>1</sup> Хөдөлмөрийн зах зээлийн 2025 оны үзүүлэлтүүд 2026 оны 7 дугаар сард зарлагдана.

## Зураг 2. Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд

1. Ажиллагчид, ажилгүй хүний тоо (мянган хүн)




2. Ажиллах хүчний оролцооны түвшин, ажилгүйдлийн түвшин (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, ЭЗХЯ-ны тооцоолол  
Тэмдэглэл: 2025\* оны хүлээгдэж буй гүйцэтгэл.

## Зураг 3. Хүн амын насны суврага



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, ЭЗХЯ-ны тооцоолол

Түүнчлэн ажиллах хүчний нийт хэмжээ 2025 онд 1 сая 437.3 мянган хүн болж, өмнөх оноос 3.8 мянган хүнээр буюу 0.3 хувиар бага зэрэг буурсан байна. Үүнтэй уялдан ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны 61.3 хувиас 61.1 хувь болж 0.2 нэгж хувиар буурсан нь хөдөлмөрийн зах зээлд оролцох идэвх бага зэрэг саарсныг илтгэж байна.

Харин ажилгүй иргэдийн тоо өмнөх оноос 7.1 мянган хүнээр буюу 8.3 хувиар буурч, 78.4 мянгад хүрсэн байна. Үүний үр дүнд ажилгүйдлийн түвшин 2024 оны 5.9 хувиас 2025 онд 5.5 хувь болж 0.4 нэгж хувиар буурсан нь хөдөлмөрийн зах зээлийн чанарын үзүүлэлт тодорхой хэмжээгээр

сайжирсныг харуулж байна.

**Гадаад худалдаа.** Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 онд 27.0 тэрбум ам.долларт хүрсэн бол гадаад худалдааны тэнцэл 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Экспорт 2025 онд 15.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны түвшинд хадгалагдав. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ өссөн нь нүүрсний үнийн бууралтаас шалтгаалсан экспортын орлогын алдагдлыг нөхлөө.


Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт 14.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны түвшинд байна. Уул уурхайн биржээр арилжаалсан бүтээгдэхүүнийг хилийн боомтоор саадгүй нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, хил, гаалийн үйл ажиллагааг цахимжуулснаар нүүрсний экспорт 90.0 сая тоннд хүрч, өмнөх оноос 7 хувиар өссөн байна. Түүнчлэн далд уурхайн олборлолт нэмэгдэж, тээвэр зохион байгуулалт сайжирсантай холбоотойгоор зэсийн баяжмалын экспортын хэмжээ өмнөх оноос 35 хувиар, төмрийн хүдрийн экспорт 17 хувиар тус тус өсөж, нүүрсний үнийн бууралтаас үүдэлтэй орлогын алдагдлыг нөхсөн байна.

Уул уурхайн бус экспорт 1.2 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 3.8 хувиар өсөв. Үүнээс хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт 672 сая ам.долларт хүрч 7.1 хувиар нэмэгдсэн бол, аж үйлдвэрийн салбарын экспорт 498 сая ам.долларт хүрч 0.6 хувиар буурсан байна. Боловсруулах салбарын өсөлтийн нөлөөгөөр ноолуур, мах болон аж үйлдвэрийн зарим бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн. Түүнчлэн түүхий ноолуурын экспортод хязгаарлалт тавьж, самнасан ноолуурын үйлдвэрлэлийг дэмжсэн бодлогын үр дүнд ноолуурын экспортын орлого өсөхөд эерэг нөлөө үзүүлжээ

#### Зураг 4. Гадаад худалдааны үзүүлэлт

1.Гадаад худалдаа

(тэрбум ам.доллар)




2.Экспортын жилийн өсөлт

(хувь)



3.Импортын жилийн өсөлт

(хувь)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тэмдэглэл: Импортын бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний зориулалтаар ангилав.


Импорт 2025 онд 11.3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 221 сая ам.доллараар буюу 1.9 хувиар буурлаа. Импортын өөрчлөлтийг хэрэглээний

зориулалтаар авч үзвэл нийт бууралтын 1.6 нэгж хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 0.2 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 0.3 нэгж хувийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бүрдүүлсэн байна. 2024 онд уул уурхайн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт өндөр байсан суурийн нөлөөгөөр 2025 онд уул уурхайн салбарт ашиглагддаг завсрын болон хөрөнгө оруулалтын барааны импорт саарчээ. Тухайлбал, экскаватор, шанагат ухагчийн импорт 298 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 18 орчим хувиар, ачаа бараа тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгслийн импорт 505 сая ам.доллар болж, 30 гаруй хувиар тус тус буурсан байна. Харин уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээний экспорт өссөнтэй холбоотойгоор дизель түлшний импорт 1,343 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 3.7 хувиар өсөв. Суудлын автомашин, түүний сэлбэг хэрэгслийн импорт буурсан нь хэрэглээний бүтээгдэхүүний импортыг буурууллаа. Нийслэл хотод 10-аас дээш жилийн насжилттай суудлын автомашинд тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар олгохгүй гэж шийдвэрлэсэнтэй холбоотойгоор суудлын автомашины импорт өмнөх оноос 4.1 хувиар буурсан байна. Суудлын автомашины импортыг даган автобензиний импорт 604 сая ам.долларт хүрч, мөн 5.4 хувиар буурав. Харин хүнс, эм тариа зэрэг өрхийн зайлшгүй хэрэгцээт бүтээгдэхүүний импорт харьцангуй тогтвортой хадгалагдлаа.


**Төлбөрийн тэнцэл:** Төлбөрийн тэнцэл 2025 оны эцэст 1,034 сая ам.долларын ашигтай гарч, гадаад валютын улсын нөөц 7,005 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 1,495 сая ам.доллараар нэмэгдлээ. Нүүрсний үнийн уналтаас шалтгаалан 2025 оны эхний хагаст экспортын орлого буурч, төлбөрийн тэнцэл алдагдалтай байсан ч Засгийн газраас экспортын орлого, санхүүгийн дансны ашгийг нэмэгдүүлэх замаар гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж оны сүүлийн хагас экспорт эрчимжиж урсгал данс алдагдал буурч 2.1 тэрбум ам.долларт хүрлээ. Мөн импорт өмнөх оноос 2.6 хувиар буурсан нь урсгал дансны алдагдал буурахад нөлөөллөө.

**Зураг 5. Төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц**

1. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)



2. Гадаад валютын улсын нөөц (сая ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк

## 1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2025 онд 33,179.2 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд 562.5 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 1,710.6 тэрбум төгрөг, Хуримтлалын санд 602.9 тэрбум төгрөгийг хуваарилсан. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 30,303.2 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31,331.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,027.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь дотоодын нийт бүтээгдэхүүн<sup>2</sup>-ий 1.1 хувьтай тэнцэж байна.

**Зураг 6. Монгол Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт /2019-2025 он, тэрбум төгрөг/**



**Тогтворжуулалтын сан:** Төсвийн тогтворжуулалтын санд төлөвлөсөн хэмжээнээс 133.4 тэрбум төгрөгөөр илүү буюу 562.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

**Хуримтлалын сан:** Хуримтлалын санд 2025 онд 562.1 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдаж, 602.9 тэрбум төгрөг төвлөрөн 107.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

<sup>2</sup> ДНБ-ний урьдчилсан гүйцэтгэл, оны үнээр – 79,956,293.3 сая төгрөг  
Эх сурвалж Үндэсний статистикийн хороо

**Ирээдүйн өв сан:** Ирээдүйн өв санд 2025 онд 1,394.1 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдаж, 1,710.6 тэрбум төгрөг төвлөрөн 122.7 хувийн гүйцэтгэлтэй байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар тус сангийн хуримтлал 5,323.9 тэрбум төгрөг байна.



## 1.1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 онд 30,303.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 4.5 хувь буюу 1,428.4 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэлийг 2024 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 632.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлт 95.9 хувь, орон нутгийн төсвийн орлогын биелэлт 90.8 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын биелэлт 93.3 хувь, нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт 96.8 хувь байна.

### Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлого /тэрбум төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ                                            | 2025 оны        |                 |               |                 |
|-----------------------------------------------------|-----------------|-----------------|---------------|-----------------|
|                                                     | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Хувь          | Зөрүү           |
| <b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>                | <b>34,116.8</b> | <b>33,179.2</b> | <b>97.3%</b>  | <b>-937.6</b>   |
| <b>ИРЭЭДҮЙН ӨВ САН</b>                              | 1,394.1         | 1,710.6         | 122.7%        | 316.5           |
| <b>ХУРИМТЛАЛЫН САН</b>                              | 562.1           | 603.0           | 107.3%        | 40.8            |
| <b>ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН</b>                         | 429.1           | 562.5           | 131.1%        | 133.4           |
| <b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b> | <b>31,731.5</b> | <b>30,303.2</b> | <b>95.5%</b>  | <b>-1,428.4</b> |
| <b>1. Татварын орлого</b>                           | <b>29,241.6</b> | <b>27,212.9</b> | <b>93.1%</b>  | <b>-2,028.7</b> |
| Орлогын албан татвар                                | 9,370.9         | 8,560.3         | 91.4%         | -810.6          |
| ААН-ын орлогын албан татвар                         | 6,338.3         | 5,665.0         | 89.4%         | -673.4          |
| Нийгмийн даатгалын орлого                           | 5,980.5         | 5,623.2         | 94.0%         | -357.4          |
| Хөрөнгийн албан татвар                              | 593.8           | 609.8           | 102.7%        | 15.9            |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар                      | 6,646.8         | 6,207.3         | 93.4%         | -439.4          |
| Онцгой албан татвар                                 | 1,254.5         | 949.0           | 75.6%         | -305.5          |
| Тусгай зориулалтын орлого                           | 31.5            | 25.5            | 80.9%         | -6.0            |
| Гадаад үйл ажиллагааны орлого                       | 2,114.0         | 1,842.2         | 87.1%         | -271.8          |
| Бусад татвар, төлбөр, хураамж                       | 3,249.5         | 3,395.6         | 104.5%        | 146.1           |
| Бусад нийтлэг төлбөр, хураамж                       | 2,777.1         | 2,998.0         | 108%          | 220.9           |
| Газрын төлбөр                                       | 313.8           | 237.2           | 75.6%         | -76.6           |
| <b>2.Татварын бус орлого</b>                        | <b>2,489.9</b>  | <b>3,090.2</b>  | <b>124.1%</b> | <b>600.3</b>    |

Тайлант онд татварын орлогын бүрдүүлэлт 27,212.9 тэрбум төгрөгт хүрч, 93.1 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Орлогын албан татвар 810.6 тэрбум төгрөгөөр, Онцгой албан татвар 305.5 тэрбум төгрөгөөр, Нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 439.4 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 357.4 тэрбум төгрөгөөр, Гадаад үйл ажиллагааны орлого 271.8 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс дутуу биелсэн нь татварын орлогын гүйцэтгэл төлөвлөсөн дүнгээс 2,028.7 тэрбум төгрөгөөр дутуу биелэхэд голлон нөлөөлсөн байна.

## 1.2. НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 онд батлагдсанаар хөшөө дурсгал, угтах хаалга барьж байгуулах болон дэд, орлогч дарга нарын орон тоо, автомашины хэрэглээг хязгаарласан нь төсвийн сахилга хариуцлагыг чангатгах, төрийн үрэлгэн байдлын эсрэг соёл, чиг хандлагыг тогтоох эерэг үр дагавартай болсон.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2025 онд 31,331.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 11.4 хувь буюу 4,032.4 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

### Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн зарлага /тэрбум төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ                                                    | 2025 оны   |           |      |          |
|-------------------------------------------------------------|------------|-----------|------|----------|
|                                                             | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү    |
| <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                    | 35,363.4   | 31,331.0  | 88.6 | -4,032.4 |
| <b>А. УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     | 25,970.8   | 24,237.8  | 93.3 | -1,094.0 |
| <b>1. Бараа, ажил үйлчилгээний зардал</b>                   | 11,218.8   | 10,124.8  | 90.2 | -1,094.0 |
| 1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 6,473.5    | 6,229.1   | 96.2 | -244.4   |
| 2. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 0.0        | 0.0       | 0.0  | 0.0      |
| 3. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 716.4      | 604.4     | 84.4 | -112.0   |
| 4. Хангамж, бараа материалын зардал                         | 310.1      | 278.4     | 89.8 | -31.6    |
| 5. Нормативт зардал                                         | 423.9      | 309.2     | 72.9 | -114.7   |
| 6. Эд хогшил, урсгал засварын зардал                        | 272.1      | 226.3     | 83.2 | -45.8    |
| 7. Томилолт, зочны зардал                                   | 107.2      | 86.5      | 80.7 | -20.7    |
| 8. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,676.2    | 1,355.3   | 80.8 | -320.8   |
| 9. Бараа үйлчилгээний бусад зардал                          | 1,239.4    | 1,035.4   | 83.5 | -204.00  |
| <b>2. Хүү</b>                                               | 1,633.7    | 1,548.2   | 94.8 | -85.6    |
| <b>3. Татаас</b>                                            | 1,055.3    | 799.6     | 79.5 | -205.7   |
| <b>4. Урсгал шилжүүлэг</b>                                  | 12,112.9   | 11,765.1  | 97.1 | -347.8   |
| <b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                  | 9,553.6    | 7,074.0   | 74.0 | -2,479.6 |
| 1. Барилга байгууламж                                       | 6,862.3    | 5,158.1   | 75.2 | -1,704.2 |
| 2. Их засвар                                                | 521.9      | 381.2     | 73.0 | -140.7   |
| 3. Тоног төхөөрөмж                                          | 756.1      | 596.3     | 78.9 | -159.7   |
| 4. Бусад хөрөнгө                                            | 1,401.7    | 934.2     | 66.6 | -467.5   |
| 5. Стратегийн нөөц хөрөнгө                                  | 11.5       | 4.1       | 35.6 | -7.4     |
| <b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>        | -161.0     | 19.2      |      | 180.2    |
| 1. Эргэж төлөгдөх зээл                                      | -369.7     | -186.7    | 50.5 | 183.0    |
| 2. Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл                  | 208.7      | 205.9     | 98.6 | -2.8     |

Хөрөнгийн зардал 2,479.6 тэрбум төгрөг, бараа, ажил үйлчилгээний зардал 1,094.. тэрбум төгрөг, урсгал шилжүүлгийн зардал 347.8 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан нь нийт зардлын гүйцэтгэл 88.6 хувийн гүйцэтгэлтэй гарахад голлон нөлөөлсөн байна.

Улсын төсөв 9.5 хувь буюу 2,150.0 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 23.8 хувь буюу 2,548.6 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн дүнгээс дутуу гүйцэтгэлтэй байгаа нь Нэгдсэн төсвийн нийт зарлагын зарцуулагдаагүй үлдэгдэл 4,032.4 тэрбум төгрөгт голлон нөлөөлсөн байна.

**Хүснэгт 4. Төсвүүдийн нийт зарлага ба цэвэр зээл / тэрбум төгрөг/**

| Төсвийн бүрэлдэхүүн                   | 2025 оны        |                 |                  |
|---------------------------------------|-----------------|-----------------|------------------|
|                                       | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Зөрүү*           |
| <b>Нэгдсэн төсөв</b>                  | <b>35,363.4</b> | <b>31,331.0</b> | <b>(4,032.4)</b> |
| Улсын төсөв                           | 22,564.3        | 20,414.3        | (2,150.0)        |
| Орон нутгийн төсөв                    | 10,721.1        | 8,172.4         | (2,548.6)        |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв | 2,164.8         | 2,238.3         | 73.4             |
| Нийгмийн даатгалын сангийн төсөв      | 5,802.2         | 5,846.9         | (44.7)           |

\*Төсөв хоорондын дотоод шилжүүлэг

### 1.3. НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,027.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

#### Хүснэгт 5. Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл /тэрбум төгрөг/

| Төсвийн бүрэлдэхүүн                   | 2025 оны    |           |         |
|---------------------------------------|-------------|-----------|---------|
|                                       | Төлөвлөгөө* | Гүйцэтгэл | Зөрүү   |
| <b>Нэгдсэн төсөв</b>                  | -3,631.9    | -1,027.9  | 2,604.0 |
| Улсын төсөв                           | -2,769.3    | -1,426.3  | 1,343.0 |
| Орон нутгийн төсөв                    | -2,267.9    | -500.3    | 1,767.6 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв | 299.5       | 61.2      | -238.2  |
| Нийгмийн даатгалын сангийн төсөв      | 1,105.9     | 837.5     | -268.3  |

\*Төсвийн тухай хуулийн 57, 64 дүгээр зүйлд заасны дагуу 2025 онд ороннутгийн төсөвт Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан төсвийн орлого, зардлын дүнг үндэслэн тооцов.

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,426.3 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн тэнцэл 500.3 тэрбум төгрөгийн алдагдалтай, харин Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 61.2 тэрбум төгрөгийн, Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 837.5 тэрбум төгрөгийн ашигтай байна.

Тайлант онд Засгийн газрын гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 1,731.5 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 14.3 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлсэн.

#### Хүснэгт 6. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр /тэрбум төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ                                          | Нэгдсэн төсөв   | Улсын төсөв     | Орон нутгийн төсөв | ЭМДС         | НДС           |
|---------------------------------------------------|-----------------|-----------------|--------------------|--------------|---------------|
| <b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>                 | <b>-1,027.9</b> | <b>-1,426.3</b> | <b>-500.3</b>      | <b>61.2</b>  | <b>837.5</b>  |
| <b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>           | <b>1,027.9</b>  | <b>1,426.3</b>  | <b>500.3</b>       | <b>-61.2</b> | <b>-837.5</b> |
| Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 39.8            | 1,053.4         | -114.8             | -61.3        | -837.5        |
| <b>ЗГ-ын бонд</b>                                 | <b>891.3</b>    | <b>280.2</b>    | <b>611.1</b>       | <b>0.0</b>   | <b>0.0</b>    |
| <b>Урт хугацаат</b>                               | <b>891.3</b>    | <b>280.2</b>    | <b>611.1</b>       | <b>0.0</b>   | <b>0.0</b>    |
| <b>Дотоод</b>                                     | <b>588.5</b>    | <b>280.2</b>    | <b>308.3</b>       | <b>0.0</b>   | <b>0.0</b>    |
| Шинээр гаргах                                     | 602.8           | 294.5           | 308.3              | 0.0          | 0.0           |
| Үндсэн төлбөр                                     | -14.3           | -14.3           | 0.0                | 0.0          | 0.0           |
| <b>Гадаад</b>                                     | <b>302.9</b>    | <b>0.0</b>      | <b>302.9</b>       | <b>0.0</b>   | <b>0.0</b>    |
| Үндсэн төлбөр                                     | -1,731.5        | -1,731.5        | 0.0                | 0.0          | 0.0           |
| <b>ЗГ-ын зээл</b>                                 | <b>92.2</b>     | <b>92.2</b>     | <b>0.0</b>         | <b>0.0</b>   | <b>0.0</b>    |
| <b>Гадаад</b>                                     | <b>92.2</b>     | <b>92.2</b>     | <b>0.0</b>         | <b>0.0</b>   | <b>0.0</b>    |

|                                                    |               |               |            |            |            |
|----------------------------------------------------|---------------|---------------|------------|------------|------------|
| <b>Төслийн зээл</b>                                | <b>621.4</b>  | <b>621.4</b>  | <b>0.0</b> | <b>0.0</b> | <b>0.0</b> |
| Шинээр авах                                        | 1,504.2       | 1,504.2       | 0.0        | 0.0        | 0.0        |
| Үндсэн төлбөр                                      | -882.8        | -882.8        | 0.0        | 0.0        | 0.0        |
| <b>Хөтөлбөрийн зээл</b>                            | <b>-529.1</b> | <b>-529.1</b> | <b>0.0</b> | <b>0.0</b> | <b>0.0</b> |
| Шинээр авах                                        | 0.0           | 0.0           | 0.0        | 0.0        | 0.0        |
| Үндсэн төлбөр                                      | -529.1        | -529.1        | 0.0        | 0.0        | 0.0        |
| Тогтворжуулалтын сангийн<br>хуримтлагдсан үлдэгдэл | 0.0           | 0.0           | 0.0        | 0.0        | 0.0        |
| Өмч хувьчлал                                       | 4.4           | 0.4           | 0.0        | 0.0        | 0.0        |

#### 1.4. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

Улсын Их Хурлаас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг төсвийн тусгай шаардлагад бүрэн нийцүүлэн боловсруулж, батлуулсан.

**Төсвийн орлогын тусгай шаардлага:** Монгол Улсын 2025 оны төсвийн орлогыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан “Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх” тусгай шаардлагын дагуу боловсруулан батлуулж, төсвийн жилийн турш уг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан ажиллалаа.

Төсвийн төсөлд тусгасан гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэхээс гадна макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон.

**Төсвийн суурь тэнцлийн тусгай шаардлага:** Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх шаардлагыг хангаж байна.

##### Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь

|                 | 2025 |
|-----------------|------|
| Хуулийн хязгаар | 2.0  |
| Гүйцэтгэл       | 1.1  |

**Урсгал зарлагын тусгай шаардлага:** Нэгдсэн төсвийн урсгал зардлыг ДНБ-ний 30 хувиас хэтрүүлэхгүй байх бодлого баримталж, зарлагын өсөлтийг хүн ам зүйн статистик өөрчлөлтөөр нэмэгдэх нийгмийн суурь үйлчилгээ болон инфляц, ханшийн өөрчлөлттэй уялдаж нэмэгдэх бараа, ажил, үйлчилгээний зардалд голлон чиглүүлж, төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах, төрийн байгууллагуудын орон тооны давхардлыг арилгах, төрийн үйл ажиллагааг хүрэх үр дүн, гүйцэтгэлд суурилж санхүүжүүлэх бодлого баримталсан. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь 2025 онд 26.9 байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т заасан тусгай шаардлагыг хангаж байна.

##### Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь

|                 | 2025  |
|-----------------|-------|
| Хуулийн хязгаар | 30.0% |
| Гүйцэтгэл       | 26.9% |

**Өрийн тусгай шаардлага:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх.” гэж заасан. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2024-2026 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

##### Хүснэгт 9. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь

|                 | <b>2024</b> | <b>2025</b> |
|-----------------|-------------|-------------|
| Хуулийн хязгаар | 60.0%       | 60.0%       |
| Гүйцэтгэл       | 41.8%       | 39.4%       |

## 1.5. ТАТВАРЫН ЗАРЛАГА

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д “татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэлнэ, мөн Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлд татварыг зөвхөн хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй гэж тус тус заасан байна.

Хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2025 оны гүйцэтгэлээр 1,698.7 тэрбум төгрөг<sup>3</sup> буюу нэгдсэн төсвийн нийт орлогын 5.2 хувьд хүрэхээр байна. Татварын зарлагын хэмжээг татвар, гаалийн байгууллагаар харуулбал дараах байдалтай байна.

**Хүснэгт 10. Татварын зарлагын хэмжээ/ тэрбум төгрөг/**

| Байгууллага                           | Татварын дүн   | Татвар төлөгчийн тоо |
|---------------------------------------|----------------|----------------------|
| <b>Татварын байгууллага</b>           | <b>1,571.1</b> | <b>1,555,493</b>     |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 1,042.4        | 11,281               |
| Хувь хүний орлогын албан татвар       | 204.1          | 1,520,747            |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар        | 324.5          | 23,465               |
| <b>Гаалийн байгууллага</b>            | <b>127.7</b>   | <b>926</b>           |
| Гаалийн албан татвар                  | 78.7           | 556                  |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар        | 48.9           | 370                  |
| <b>Нийт татварын зарлага</b>          | <b>1,698.7</b> | <b>1,556,419</b>     |

Хүснэгтээс харахад нийт татварын зардал буюу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 92.5 хувь буюу 1,571.1 тэрбум төгрөгийг татварын алба, 7.5 хувь буюу 127.7 тэрбум төгрөгийг гаалийн байгууллага холбогдох шийдвэрийн дагуу хэрэгжүүлсэн байна.

<sup>3</sup> Сангийн сайдын 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 99 дугаар тушаалаар батлагдсан “Татварын зарлагад шинжилгээ хийх, гүйцэтгэлийг тайлагнах журам”-д заасны дагуу зарим төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын зарлагад хамруулахгүйгээр туссан бөгөөд журамд заасны дагуу татварын зарлагын гүйцэтгэлийн мэдээг гаргав.

Татварын ерөнхий газрын ирүүлсэн мэдээлэл нь Татварын ерөнхий хууль-ийн 13 дугаар зүйл “Нууцлалын баталгаа” болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль-д заасан хамгаалагдсан мэдээлэлд хамаарч байгаа тул татвар төлөгчийн мэдээллийг задруулахыг хориглосон зохицуулалтын хүрээнд мэдээллийг далдлан (маскалж) ирүүлсэн болно.



## 1.6. ХУДАЛДАН АВСАН БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3 дахь хэсэгт заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д /цаашид “цахим систем” гэх/ нийтэлсэн төлөвлөгөө, түүний биелэлт, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн мөн журмын 4 дэх хэсэгт заасны дагуу хяналт тавьж, дүн шинжилгээ хийсэн болно.

- **Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулсан байдал:**

Тайлант хугацаанд 60 төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 2,483 захиалагчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэлээ.

Улсын хэмжээнд 46,210.74 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 20,433 төсөл, арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж, 31,247.98 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15,584 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт зохион байгуулсан байна. Үүнээс 17,793.96 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13,351 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан байх бөгөөд нийт иргэн, аж ахуйн нэгж, хуулийн этгээдтэй 16,341.59 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 22,504 гэрээ байгуулах эрх олгосон байна.

**Зураг 7. Төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт**



Төсөвт өртгөөр авч үзвэл төлөвлөсөн төсөл, арга хэмжээний тоо 2,195 нэгжээр буюу 9.7% буурсан байхад төсөвт өртөг 9,819.01 тэрбум төгрөг (+27%), зарласан тендер шалгаруулалтын төсөвт өртөг 1,011.38 тэрбум төгрөг (+3.3%), зарлаагүй төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 8,807.63 тэрбум төгрөг (+143%) буюу

2024 онтой харьцуулбал хоёр дахин өссөн байх ба нийт төлөвлөгөөний гуравны нэг орчим зарлагдаагүй үлдсэн байна.

#### Хүснэгт 11.Төсөл, арга хэмжээний хэрэгжилт /төсөвт өртөг, тэрбум төгрөг/

| Он   | Төлөвлөсөн | Зарласан  | ГБЭО      | Зарлаагүй |
|------|------------|-----------|-----------|-----------|
| 2024 | 36,391.73  | 30,236.60 | 19,649.05 | 6,155.13  |
| 2025 | 46,210.74  | 31,247.98 | 17,793.96 | 14,962.76 |

15,584 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт зохион байгуулж 13,351 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулсан. 2,068 буюу төсөл, арга хэмжээний 14%-д гүйцэтгэгч шалгараагүй байгаа нь 2024 онтой ижил түвшинд байна. Үүнээс 1,022 буюу 49%-д нэг ч оролцогч тендер ирүүлээгүй, харин 1,046 буюу 51%-д шаардлага хангасан тендер ирүүлсэн оролцогч байгаагүй байна.

Түүнчлэн 2024 онд төлөвлөсөн төсөвт өртгийн 54%-д гэрээ байгуулах эрх олгосон бол 2025 онд төлөвлөгдсөн төсөвт өртгийн 39%-д гэрээ байгуулах эрх олгосон байна. 2025 онд төсөвт өртгийн тоо хэмжээ өссөн ч хэрэгжилт (ГБЭО) 15%-аар буурсан нь худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийн хооронд зөрүү үүсгэж байна.


Төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт зарласан байдал: Цахим системээс үзэхэд 2025 онд захиалагч 15,584 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа 26,149 зарлал<sup>1</sup> нийтэлсэн байх ба нэг тендер шалгаруулалт дунджаар 1.68 удаа зарлагдсан байна. 2024 онд 16,994 тендер шалгаруулалтад 31,410 зарлал нийтлэгдэж, нэг тендер шалгаруулалтад ногдох зарлалын дундаж 1.85 байсан бол 2025 онд уг дундаж 0.17 нэгжээр буурсан байна.

#### Хүснэгт 12. Тендер шалгаруулалтын зарлал

| Үзүүлэлт            | 2024         | 2025         | Өөрчлөлт       |
|---------------------|--------------|--------------|----------------|
| Тендер шалгаруулалт | 16,994       | 15,584       | -8.3% буурсан  |
| Зарлал              | 31,410       | 26,149       | -16.7% буурсан |
| Оролцогчтой зарлал  | 21,083 (67%) | 19,085 (73%) | +6.0% өссөн    |
| Оролцогчгүй зарлал  | 10,327 (33%) | 7,064 (27%)  | -6% буурсан    |

Нийт зарлалын 7,064 буюу 27%-д аж ахуйн нэгж, байгууллага тендер<sup>2</sup> ирүүлээгүйгээс шалтгаалан дахин нийтлэгдсэн байгаа бол 19,085 буюу 73%-д оролцогч тендер ирүүлсэн байна. Үүнийг нэг оролцогчтой болон хоёр эсхүл түүнээс дээш оролцогчтой зарлал гэсэн ангиллаар авч үзвэл 11,608 буюу 61% нь хоёр эсхүл түүнээс дээш оролцогчтой, 39% нь нэг оролцогчтой байна. 2024 онд нэг оролцогчтой зарлалын тоо 9,469 байсан бол 2025 онд 7,477 болж, 21%-аар буурсан байна.

**Зураг 8. Зарлал**



Худалдан авах ажиллагаанд аж ахуйн нэгж байгууллагын оролцсон байдал: Цахим системд 2025 оны байдлаар 28,945 аж ахуйн нэгж, иргэн бүртгэлтэй байна. Үүнээс 27 хувь буюу 7,739 аж ахуйн нэгж тендер шалгаруулалтад оролцсон байх ба тендер шалгаруулалтад оролцогчийн тоо 2024 оноос 441 буюу 6 хувиар нэмэгдсэн байна. Нийт тендер шалгаруулалтад оролцсон 7,739 аж ахуйн нэгжээс 5,236 аж ахуйн нэгж нэг болон түүнээс дээш удаа шалгарч гэрээ байгуулах эрх авсан бол 2,503 оролцогч гэрээ байгуулах эрх авч чадаагүй байна (Хүснэгт 13).

**Хүснэгт 13. Оролцогчдын судалгаа**

| Он   | Дундаж оролцогч | Нэг оролцогчийн илгээсэн тендерийн дундаж | Нэг оролцогчийн ГБЭО авсан дундаж |
|------|-----------------|-------------------------------------------|-----------------------------------|
| 2024 | 3.0             | 8.6                                       | 3.1                               |
| 2025 | 3.5             | 8.5                                       | 2.9                               |


Нийт 7,739 аж ахуйн нэгж давхардсан тоогоор цахим системээр дамжуулан 66,076 тендер илгээсэн. Үүнээс нэг аж ахуйн нэгж дунджаар 8 тендер шалгаруулалтад оролцож, 3 тендер шалгаруулалтад шалгарч, гэрээ байгуулах эрх авсан үзүүлэлтэй байна. Дээрх хүснэгтээс харвал нэг тендер шалгаруулалтад оролцох оролцогчдын дундаж тоо өссөн бөгөөд нэг оролцогчийн гэрээ байгуулах эрх авсан дундаж тоо 0.2 нэгжээр буурсан байна.

- **Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ангиллаар:**

Тайлант хугацаанд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан нийт 60 төсвийн ерөнхийлөн захирагчийг яамд, нийслэл, аймаг, төрийн өмчийн болон оролцоотой хуулийн этгээд, бусад гэж ангилан худалдан авах ажиллагааны тоо хэмжээ, төсөвт өртөг, тендер шалгаруулалт зохион байгуулж буй байдлыг харьцууллаа.

Төрийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг харьцуулбал яамд, нийслэл, аймаг, төрийн өмчийн болон оролцоотой хуулийн этгээд, бусад ТЕЗ нарын хувьд нийт төсөл, арга хэмжээний 72–79% зарлагдсан байгаа боловч 60–68%-д гэрээ байгуулах эрх олгогдсон байна.

**Зураг 9. ТЕЗ нарын ТШ төлөвлөсөн, зарласан байдал**



Яамдын түвшинд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний тоо 7,079 байсан ба 5,577 (79%) тендер шалгаруулалт зарласан байна. Үүнээс 4,756-д гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд хэрэгжилт 67%-тай байна. Аймаг, орон нутгийн хэмжээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний тоо 6,371 байсан ба үүнээс 4,916 (77%) тендер шалгаруулалт зарлаж, 4,232 тендер шалгаруулалтад гэрээ байгуулах эрх олгосон байх ба төлөвлөгөөний хэрэгжилт 66%-тай байна. Төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой нийт хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний тоо 3,586 байсан байх ба үүнээс 2,600 (72%) тендер шалгаруулалт зарлаж, 2,141-д гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд хэрэгжилт 60%-тай байна. Нийслэл, түүний харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2,614 төсөл, арга хэмжээ тусгагдсан ба үүнээс 1,902 (73%) тендер шалгаруулалт зарласан байна. Үүнээс 1,693-д гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд хэрэгжилт 65 хувьтай байна. Бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын түвшинд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 783 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас 589 (75%) тендер шалгаруулалт зарласан байна. Үүнээс 529-д гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд хэрэгжилт 68 хувьтай байна.


2025 оны байдлаар яам, аймаг, нийслэлийн хэмжээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 65–67% буюу цахим системд төлөвлөсөн

төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч шалгарсан бол төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааны хэрэгжилт 60% хувьтай байгаа нь хамгийн бага үзүүлэлт болсон байна. 2024 оны тоон мэдээллээр нийт худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөвт өртөг 36,391.73 тэрбум төгрөг байсан бөгөөд үүнээс 19,649.05 тэрбум төгрөг буюу 54%-д гэрээ байгуулах эрх олгогдсон ба хэрэгжилт 46%-тай байна.

Төсөвт өртгөөр авч үзвэл яамдын түвшинд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөвт өртөг 7,081.38 тэрбум төгрөг байсан бөгөөд үүнээс 62 хувьд гэрээ байгуулах эрх олгосон байна. Аймаг, орон нутгийн хэмжээнд 2025 оны төлөвлөгөөний төсөвт өртөг 1,698.98 тэрбум төгрөг байсан бөгөөд үүнээс 70 хувьд, Нийслэл, түүний харьяа байгууллагуудын төлөвлөгөөний төсөвт өртөг 26,159.42 тэрбум төгрөг тусгагдсан бөгөөд үүнээс 25 хувьд, Төрийн өмчит болон оролцоотой хуулийн этгээдийн төлөвлөгөөний төсөвт өртөг 10,981.56 тэрбум төгрөг байсан бөгөөд үүнээс 51 хувьд, бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын төлөвлөгөөний төсөвт өртөг 289.40 тэрбум төгрөг байсан бөгөөд үүнээс 82 хувьд тус тус гэрээ байгуулах эрх олгосон байна.

Ерөнхийд нь авч үзвэл, улсын хэмжээнд төлөвлөсөн 46,210.74 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааны төсөвт өртгөөс 17,793.96 тэрбум төгрөг буюу 39% нь гэрээ байгуулах эрх олгогдсон байна. Энэ нь төлөвлөсний 61% нь хэрэгжээгүй үлдсэн гэсэн дүн гаргаж байгаа бөгөөд нийслэлийн хэрэгжилт хамгийн сул, бусад ТЕЗ нарын хувьд хамгийн өндөр хэрэгжилттэй байна.

**Зураг 10. Төлөвлөгөө/төсөвт өртгийн бүтэц**



ГБЗО/төсөвт өртгийн бүтэц

Дээрх зурагаас харвал 2025 оны худалдан авах ажиллагааны төсөвт өртгийн 26,159.42 тэрбум төгрөг буюу 57 хувийг нийслэл, 10,981.56 тэрбум төгрөг буюу 24 хувийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, 7,081.38

тэрбум төгрөг буюу 15 хувийг яамд, 1,698.98 тэрбум төгрөг буюу 4 хувийг аймгууд, 289.40 тэрбум төгрөг буюу 1 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагч санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гэрээ байгуулах эрх олгосон төсөл, арга хэмжээний төсөвт өртгөөр харьцуулбал нийслэл 6,415.93 тэрбум төгрөг буюу 36 хувийг, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 5,590.14 тэрбум төгрөг буюу 31 хувийг, яамд 4,358.82 тэрбум төгрөг буюу 24 хувийг, аймгууд 1,190.84 тэрбум төгрөг буюу 7 хувийг, бусад ТЕЗ нар 238.24 тэрбум төгрөг буюу 1 хувийг тус тус эзэлж байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөвт өртгөөр үзвэл 2024–2025 оны хооронд нийслэлд төвлөрөх төсөв улам нэмэгдэж, харин төрийн өмчийн болон оролцоотой байгууллагын төсөв буурсан байх бөгөөд яам, аймаг, бусад ТЕЗ-ийн эзлэх хувь тогтвортой байна. Хэрэгжилтээр үзвэл, 2024–2025 оны хооронд төлөвлөгөөнд эзлэх нийслэлийн төсөл, арга хэмжээний төсөв нэмэгдсэн ч хэрэгжилт буурсан, төрийн өмчит болон оролцоотой хуулийн этгээдийн хэрэгжилт тогтвортой, яам, аймаг, бусад ТЕЗ нарын хувьд өөрчлөлт багатай байна.

Тайлант хугацаанд 17,793.96 тэрбум төгрөгийн төсөвт тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулж, нийт иргэн, аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд 16,341.59 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулах эрх олгож, 1,452.37 төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Үүнийг төсвийн ерөнхийлөн захирагчийн ангиллаар үзвэл бусад ТЕЗ нар 12.8 хувь, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд 12.0 хувь, яамд 10.3 хувь, нийслэл, түүний харьяа байгууллагууд 4.1 хувь, аймгууд 3.0 хувьтай тэнцүү хэмжээний хэмнэлт гаргасан байна.

Цахим системээр 2025 онд зарласан тендер шалгаруулалтын тоог зарлалын тоотой харьцуулж, төсвийн ерөнхийлөн захирагчаар ангилбал нийт төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэмжээнд зарласан тендер шалгаруулалтын 73 хувь оролцогчтой, 27 хувь оролцогчгүй байна. Тухайлбал, яамдын зарласан тендер шалгаруулалтын 70 хувь, аймгаас зарласан тендер шалгаруулалтын 71.6 хувь, нийслэлээс зарласан тендер шалгаруулалтын 76.6 хувь, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зарласан тендер шалгаруулалтын 77.8 хувь, бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын зарласан тендер шалгаруулалтын 81.7 хувьд оролцогчтой байна.


Түүнчлэн, нийслэлийн хувьд нэг тендер шалгаруулалтад ногдох зарлалын тоо 2.01, уг дундаж яамдын хувьд 1.9, аймгийн хувьд 1.86, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьд 1.64, бусад ТЕЗ нарын хувьд 1.62 тус тус ногдож байна (Хүснэгт 14).

| Хүснэгт 14. Төсөл, арга хэмжээний ТШ зарласан байдал, ангиллаар |                    |                   |                          |                          |                           |
|-----------------------------------------------------------------|--------------------|-------------------|--------------------------|--------------------------|---------------------------|
| ТЕЗ                                                             | Зарласан ТШ-ын тоо | Нийт зарлалын тоо | Оролцогчтой зарлалын тоо | Оролцогчгүй зарлалын тоо | Оролцогчтой зарлалын хувь |
| АЙМАГ                                                           | 4,916              | 7,846             | 5,621                    | 2,225                    | 71.6%                     |
| БУСАД ТЕЗ                                                       | 589                | 893               | 730                      | 163                      | 81.7%                     |


|                                      |               |               |               |              |              |
|--------------------------------------|---------------|---------------|---------------|--------------|--------------|
| НИЙСЛЭЛ                              | 1,902         | 3,325         | 2,547         | 778          | 76.6%        |
| ТӨРИЙН ӨМЧИЙН<br>БОЛОН<br>ОРОЛЦООТОЙ | 2,600         | 4,137         | 3,217         | 920          | 77.8%        |
| ЯАМ                                  | 5,577         | 9,952         | 6,970         | 2,982        | 70.0%        |
| <b>Бүгд</b>                          | <b>15,584</b> | <b>26,149</b> | <b>19,085</b> | <b>7,064</b> | <b>73.0%</b> |

Худалдан авах ажиллагаанд аж ахуйн нэгж байгууллагын оролцсон байдлаар үзвэл 2025 онд улсын хэмжээнд нийт 7,739 аж ахуйн нэгж тендер шалгаруулалтад оролцсон. Үүнээс яамдын тендер шалгаруулалтад нийт оролцогчийн 4,354 буюу 56 хувь, аймгийн тендер шалгаруулалтад 3,241 буюу 42 хувь, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тендер шалгаруулалтад 2,362 буюу 31 хувь, бусад ангиллын тендер шалгаруулалтад 662 буюу 9 хувь нь оролцсон байна.

**Зураг 11. Оролцогчдын тоо, ТЭЗ ангиллаар**



**Зураг 12. Дундаж оролцогчдын тоо**



2024 онд худалдан авах ажиллагаанд оролцогчдын дундаж тоо 3.0 байсан бол 2025 онд 3.5 болж өссөн нь өрсөлдөөн нэмэгдсэнийг харуулж байна. Илүү нарийвчилбал, нийслэлийн түвшинд оролцогчдын тоо 3.1-ээс 3.4, аймгийн түвшинд 2.6-аас 3.1, яамдын хувьд оролцогчдын дундаж тоо 3.0-аас 3.5, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын хувьд 3.8-аас 4.4 оролцогч болж өссөн байна.

### **Худалдан авах ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр:**

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 онд зохион байгуулсан тендер шалгаруулалтын төсөвт өртгийг санхүүжилтийн эх үүсвэрээр нь улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн хөрөнгө, зээл, тусламж, сангийн хөрөнгө, бусад гэсэн зургаан ангиллаар нэгтгэлээ. Тухайлбал, Засгийн газрын холбогдох санг “бусад сангийн хөрөнгө”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Эрчист Монгол” ХХК, “Эрдэнэс Монгол нэгдэл” зэрэг төрийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийг “өөрийн хөрөнгө” ангилалд, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал зардлыг “улсын төсөв”, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтийг зээл, тусламжийн хөрөнгө, Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг “бусад” ангилалд хамруулсан.



Тайлант хугацаанд цахим системд 46,210.74 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 20,433 тендер шалгаруулалт зохион байгуулахаар төлөвлөж, 31,247.98 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15,584 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт зохион байгуулж, 17,793.96 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13,351 тендер шалгаруулалтад гэрээ байгуулах эрх олгосон байна. Нийт гэрээ байгуулах эрх олгосон үнийн дүн 16,341.59 тэрбум төгрөг байх бөгөөд батлагдсан төсөвт өртгөөс 1,452.37 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

Төсөвт өртгөөр авч үзвэл улсын төсөв 4,031.33 тэрбум төгрөг буюу 8.7 хувийг, орон нутгийн төсөв 23,347.91 тэрбум төгрөг буюу 50.5 хувийг, өөрийн хөрөнгө 15,007.06 тэрбум төгрөг буюу 32.5 хувийг, бусад эх үүсвэр 8.3 хувийг эзэлж байна. Төсөл, арга хэмжээний тоогоор авч үзвэл 5,264 буюу 25.8 хувийг улсын төсвөөс, 6,764 буюу 33.1 хувийг орон нутгийн төсвөөс, 7,627 буюу 37.3 хувийг өөрийн хөрөнгөөс, 778 буюу 3.8 хувийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Төлөвлөгөөнөөс 14,962.76 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4,849 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт зарлагдаагүй, тайлант хугацаанд хэрэгжээгүй байна. Энэ нь нийт төсөвт өртгийн 32.4 хувийг, тооны хувьд 23.7 хувийг эзэлж байна.

| <b>Хүснэгт 15. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт</b> |                                    |                  |                 |              |                   |                |                   |               |
|--------------------------------------------------------|------------------------------------|------------------|-----------------|--------------|-------------------|----------------|-------------------|---------------|
| <b>Төлөвлөлт /2024-2025/</b>                           |                                    |                  |                 |              |                   |                |                   |               |
| <b>Эх үүсвэр</b>                                       | <b>Төсөв өртөг /тэрбум.төгрөг/</b> |                  |                 |              | <b>Тоо хэмжээ</b> |                |                   |               |
|                                                        | <b>2024 он</b>                     | <b>2025 он</b>   | <b>Зөрүү</b>    | <b>Хувь</b>  | <b>2024 он</b>    | <b>2025 он</b> | <b>Зөрүү</b>      | <b>Хувь</b>   |
| 1.Улсын төсөв                                          | 6,742.55                           | 4,031.33         | -2,711.22       | -67.3%       | 5,469             | 5,264          | -205.00           | -3.9%         |
| 2.Орон нутгийн төсөв                                   | 14,305.23                          | 23,347.91        | 9,042.68        | 38.7%        | 8,653             | 6,764          | -1,889.00         | -27.9%        |
| 3.Өөрийн хөрөнгө                                       | 14,600.77                          | 15,007.06        | 406.29          | 2.7%         | 7,632             | 7,627          | -5.00             | -0.1%         |
| 4.Бусад                                                | 743.18                             | 3,824.44         | 3,081.26        | 80.6%        | 874               | 778            | (96.00)           | -12.3%        |
| <b>Нийт</b>                                            | <b>36,391.73</b>                   | <b>46,210.74</b> | <b>9,819.01</b> | <b>21.2%</b> | <b>22,628</b>     | <b>20,433</b>  | <b>(2,195.00)</b> | <b>-10.7%</b> |

Төлөвлөсөн тендер шалгаруулалтын тоо хэмжээ 2025 онд 10.7 орчим хувиар буурсан боловч төсөвт өртгийн хэмжээ 21.2 хувиар нэмэгдсэн (Хүснэгт 15). Төсөвт өртгийн хэмжээ нэмэгдэхэд орон нутгийн төсвийн худалдан авалтын төлөвлөгөө 38.7 хувиар буюу 9,042.68 тэрбум төгрөгөөр өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна. Уг өсөлтийн үндсэн шалтгаан нь нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээ, тухайлбал “Туулын хурдын зам”, “Сэлбэ дэд төв”, “Улаанбаатар метро” зэрэг томоохон төсөл, арга хэмжээтэй холбоотой байна.

| <b>Хүснэгт 16. Худалдан авах ажиллагааны хэрэгжилт</b> |                                    |                |              |             |                   |                |              |             |
|--------------------------------------------------------|------------------------------------|----------------|--------------|-------------|-------------------|----------------|--------------|-------------|
| <b>Төлөвлөлт /2024-2025/</b>                           |                                    |                |              |             |                   |                |              |             |
| <b>Эх үүсвэр</b>                                       | <b>Төсөв өртөг /тэрбум.төгрөг/</b> |                |              |             | <b>Тоо хэмжээ</b> |                |              |             |
|                                                        | <b>2024 он</b>                     | <b>2025 он</b> | <b>Зөрүү</b> | <b>Хувь</b> | <b>2024 он</b>    | <b>2025 он</b> | <b>Зөрүү</b> | <b>Хувь</b> |
| 1.Улсын төсөв                                          | 6,742.55                           | 4,031.33       | -2,711.22    | -67.3%      | 5,469             | 5,264          | -205.00      | -3.9%       |
| 2.Орон нутгийн төсөв                                   | 14,305.23                          | 23,347.91      | 9,042.68     | 38.7%       | 8,653             | 6,764          | -1,889.00    | -27.9%      |


|                  |                  |                  |                 |              |               |               |                   |               |
|------------------|------------------|------------------|-----------------|--------------|---------------|---------------|-------------------|---------------|
| 3.Өөрийн хөрөнгө | 14,600.77        | 15,007.06        | 406.29          | 2.7%         | 7,632         | 7,627         | -5.00             | -0.1%         |
| 4.Бусад          | 743.18           | 3,824.44         | 3,081.26        | 80.6%        | 874           | 778           | (96.00)           | -12.3%        |
| <b>Нийт</b>      | <b>36,391.73</b> | <b>46,210.74</b> | <b>9,819.01</b> | <b>21.2%</b> | <b>22,628</b> | <b>20,433</b> | <b>(2,195.00)</b> | <b>-10.7%</b> |

#### Хэрэгжилт

| Эх үүсвэр            | Төсөв өртөг /тэрбум.төгрөг/ |                  | Харьцаа            |               | Тоо хэмжээ    |               | Харьцаа        |               |
|----------------------|-----------------------------|------------------|--------------------|---------------|---------------|---------------|----------------|---------------|
|                      | Төлөвлөсөн                  | ГБЭО             | Зөрүү              | Хувь          | Төлөвлөсөн    | ГБЭО          | Зөрүү          | Хувь          |
| 1.Улсын төсөв        | 4,031.33                    | 3,238.34         | (792.99)           | -19.7%        | 5,264         | 3,296         | (1,968)        | -37.4%        |
| 2.Орон нутгийн төсөв | 23,347.91                   | 6,756.49         | (16,591.42)        | -71.1%        | 6,764         | 4,504         | (2,260)        | -33.4%        |
| 3.Өөрийн хөрөнгө     | 15,007.06                   | 3,312.11         | (11,694.95)        | -77.9%        | 7,627         | 5,086         | (2,541)        | -33.3%        |
| 4.Бусад              | 3,824.44                    | 134.68           | (3,689.76)         | -96.5%        | 778           | 465           | (313)          | -40.2%        |
| <b>Нийт</b>          | <b>46,210.74</b>            | <b>17,793.96</b> | <b>(28,416.78)</b> | <b>-61.5%</b> | <b>20,433</b> | <b>13,351</b> | <b>(7,082)</b> | <b>-34.7%</b> |

Тайлант хугацаанд нийт 20,433 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас 13,351 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Хэрэгжилтийг төсөвт өртгөөр авч үзвэл улсын төсвийн 19.7 хувь, орон нутгийн төсвийн 71.1 хувь, өөрийн хөрөнгийн 77.9 хувь, бусад эх үүсвэрийн 96.5 хувь, нийт төсөвт өртгийн 61.5 хувьд гэрээ байгуулах эрх олгоогүй буюу хэрэгжүүлээгүй байна.

#### Зураг 13. Төлөвлөгөөнд туссан гэрээ байгуулах эрх олгоогүй төсөл, арга хэмжээ



Хэрэгжилтийг тоо хэмжээгээр авч үзвэл улсын төсвөөс хэрэгжих 1,968 буюу 37.4 хувь, орон нутгийн төсвөөс хэрэгжих 2,260 буюу 33.4 хувь, өөрийн хөрөнгөөс хэрэгжих 2,541 буюу 33.3 хувь, бусад эх үүсвэрээс хэрэгжих 313 буюу 40.2 хувь, нийт 34.7 хувьтай тэнцэж байна.

2025 онд нийт гэрээ байгуулах эрх олгосон үнийн дүн 16,341.59 тэрбум төгрөг бөгөөд төсөвт өртгөөс 8.2 хувь буюу 1,452.37 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Хэмнэлтийг дараах хүснэгтээр харуулав.

#### Хүснэгт 17. Худалдан авах ажиллагааны хэмнэлт

| Төлөвлөлт /2024-2025/ |                             |            |
|-----------------------|-----------------------------|------------|
|                       | Төсөв өртөг /тэрбум.төгрөг/ | Тоо хэмжээ |


| Эх үүсвэр                   | 2024 он               | 2025 он          | Зөрүү                   | Хувь         | 2024 он          | 2025 он       | Зөрүү             | Хувь           |
|-----------------------------|-----------------------|------------------|-------------------------|--------------|------------------|---------------|-------------------|----------------|
| <b>1.Улсын төсөв</b>        | 6,742.55              | 4,031.33         | -2,711.22               | -67.3%       | 5,469            | 5,264         | -205.00           | -3.9%          |
| <b>2.Орон нутгийн төсөв</b> | 14,305.23             | 23,347.91        | 9,042.68                | 38.7%        | 8,653            | 6,764         | -1,889.00         | -27.9%         |
| <b>3.Өөрийн хөрөнгө</b>     | 14,600.77             | 15,007.06        | 406.29                  | 2.7%         | 7,632            | 7,627         | -5.00             | -0.1%          |
| <b>4.Бусад</b>              | 743.18                | 3,824.44         | 3,081.26                | 80.6%        | 874              | 778           | (96.00)           | -12.3%         |
| <b>Нийт</b>                 | <b>36,391.73</b>      | <b>46,210.74</b> | <b>9,819.01</b>         | <b>21.2%</b> | <b>22,628</b>    | <b>20,433</b> | <b>(2,195.00)</b> | <b>-10.7%</b>  |
| Санхүүжилтийн эх үүсвэр     | Зарласан төсөвт өртөг |                  | ГБЭО ТШ-ын төсөвт өртөг |              | Гэрээний үнэ     |               | Хэмнэлт           | Хэмнэлт /хувь/ |
| <b>1.Улсын төсөв</b>        | 3,585.81              |                  | 3,238.34                |              | 2,999.42         |               | 238.92            | 7.4%           |
| <b>2.Орон нутгийн төсөв</b> | 13,632.11             |                  | 6,756.49                |              | 6,527.13         |               | 229.36            | 3.4%           |
| <b>3.Өөрийн хөрөнгө</b>     | 10,351.64             |                  | 7,477.47                |              | 6,529.93         |               | 947.54            | 12.7%          |
| <b>4.Бусад</b>              | 3,678.43              |                  | 321.66                  |              | 285.11           |               | 36.56             | 11.4%          |
| <b>Нийт</b>                 | <b>31,247.98</b>      |                  | <b>17,793.96</b>        |              | <b>16,341.59</b> |               | <b>1,452.37</b>   | <b>8.2%</b>    |

Тухайлбал, тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өртгөөс улсын төсвийн хувьд 238.92 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 229.36 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 947.54 тэрбум төгрөг, бусад эх үүсвэр 36.56 тэрбум төгрөгөөр бага дүнгээр гэрээ байгуулах эрх олгосон байна.

#### **Улсын төсвийн хөрөнгө оруулалт (УТХО)-ын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны талаар:**

Цахим системээр ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр 2025 онд 38 захиалагч 2,279.49 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 255 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн. Үүнээс 2,221.86 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 245 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт зарлаж, 407 оролцогчтой 1,925.91 тэрбум төгрөгийн гэрээ байгуулах эрх олгож, 114.49 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан байна.


**Зураг 14. УТХО-ын төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг**



Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн жагсаалтаас харахад 2025 онд Зам, тээврийн сайд 1,143.55 тэрбум төгрөг (50.1%), Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд 357.69 тэрбум төгрөг (15.7%), Эрчим хүчний сайд 282.58 тэрбум төгрөг (12.4%)-ийн худалдан авалт төлөвлөж хэрэгжүүлсэн нь нийт төсвийн 78.2%-тай тэнцүү байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт зарласан хугацаа болон бараа, ажил, үйлчилгээ гэсэн ангиллаар цахим системд 255 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад холбогдох 354 зарлал нийтлэгдсэн байна. Төсөл, арга хэмжээний тоо болон зарлалын тоо зөрүүтэй буюу зарлалын тоо олон байгаа нь тухайн төсөл, арга хэмжээ нь багцад хуваагдсан, эсхүл амжилтгүй болсноор дахин зарлагдсан тохиолдлыг илэрхийлнэ. Иймд цахим систем дэх зарлалаас харвал нийт ажлын тендер шалгаруулалтын зарлал 174 байх бөгөөд үүнээс 136 буюу 78.2 хувь нь 3, 4, 5 дугаар сард нийтлэгдсэн байна. Бараа, үйлчилгээний хувьд нийт зарлалын 153 нь 3-аас 5 дугаар сард цахим системд нийтлэгдсэн байх бөгөөд энэ нь нийт бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтын 85%-ийг эзэлж байна.

**Зураг 15.** УТХО-ын төсөл, арга хэмжээний ТШ зарласан хугацаа, ангиллаар



Хуулийн дагуу төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгох тохиолдолд зарлах, хянан үзэх, үнэлэх, захиалагч шийдвэр гаргах болон гэрээ байгуулах хүртэл (Захиалагч, Монополын эсрэг газар, Сангийн яамд гомдол гараагүй гэж үзвэл) хамгийн багадаа ажлын 36 өдөр буюу ойролцоогоор календарийн 50 хоног шаардлагатай байдаг. Хэрэв гомдол гарсан тохиолдолд уг хугацаа багадаа ажлын 10 өдрөөр уртсах боломжтой. 2025 онд тендер шалгаруулалт зарласан огнооноос үр дүн (шийдвэр) нийтэлсэн захиалагчийн дундаж хугацаа хуанлийн 48.7 хоног байсан бөгөөд хуулиар уг шийдвэр нийтлэгдсэнээс хойш ажлын 6 өдрийн дараа шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах боломжтой болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтад “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах,” гэж, 13.1.2 дахь заалтад “энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох,” гэж тус тус заасан.

Дээрх графикаас үзвэл улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын зарлал 3-аас 5 дугаар сард зарлагдсан (289, 85%) байх бөгөөд хуулийн дээрх заалт, хугацаанаас үзвэл 3–4 дүгээр сард зарлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь хэмнэлтэд тооцогдох, 5 дугаар сард зарлагдсан тендер шалгаруулалтууд хуулийн хугацаанд багтахгүй тул санхүүжилт татагдах боломжтой байсан байх тул улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтыг улсын төсөв батлагдсан даруйд эхлүүлэх шаардлагатай байна.

**Хүснэгт 18. УТХО-ын төсөл, арга хэмжээний ТШ-ын төлөвлөлт, хэрэгжилт**

| ТЕЗ                                                          | Төлөвлөсөн<br>(Тоо) | Төлөвлөсөн<br>(төсөв) | Зарласан | Зарласан<br>(Төсөв) | ГБЗО<br>(тоо) | ГБЗО дүн | Хэмнэлт |
|--------------------------------------------------------------|---------------------|-----------------------|----------|---------------------|---------------|----------|---------|
| Авлигатай тэмцэх газрын дарга                                | 3                   | 2.36                  | 3        | 2.36                | 3             | 2.29     | 0.08    |
| Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд                              | 1                   | 0.98                  | 1        | 0.98                | 1             | 0.78     | 0.20    |
| Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд                | 5                   | 22.97                 | 4        | 14.78               | 4             | 15.50    | (0.72)  |
| Боловсролын сайд                                             | 34                  | 35.20                 | 33       | 30.69               | 32            | 25.69    | 4.22    |
| Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд                  | 4                   | 40.89                 | 4        | 40.89               | 4             | 36.46    | 4.43    |
| Зам, тээврийн сайд                                           | 16                  | 1,143.55              | 16       | 1,143.55            | 15            | 1,093.70 | 34.71   |
| Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга  | 8                   | 4.40                  | 7        | 3.44                | 5             | 2.50     | 0.31    |
| Ерөнхий аудитор                                              | 1                   | 1.18                  | 1        | 1.18                |               |          |         |
| Ерөнхий сайд                                                 | 1                   | 1.55                  | 1        | 1.55                | 1             | 1.43     | 0.11    |
| Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга                           | 2                   | 1.00                  | 2        | 1.00                | 2             | 0.69     | 0.31    |
| Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга | 3                   | 8.10                  | 3        | 8.10                | 3             | 5.57     | 2.53    |
| Шадар сайд /Бүсчилсэн хөгжил, онцгой байдал/                 | 3                   | 11.40                 | 3        | 11.40               | 3             | 10.89    | 0.51    |
| Сангийн сайд                                                 | 15                  | 24.87                 | 14       | 24.26               | 13            | 20.57    | 3.21    |
| Санхүүгийн зохицуулах хорооны дарга                          | 1                   | 0.25                  | 1        | 0.25                | 1             | 0.24     | 0.01    |
| Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд                | 2                   | 21.05                 | 2        | 21.05               | 1             | 1.85     | -       |
| Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч                             | 3                   | 6.55                  | 3        | 6.55                | 3             | 3.01     | 3.54    |
| Улсын ерөнхий прокурор                                       | 1                   | 3.81                  | 1        | 3.81                | 1             | 3.80     | 0.01    |
| Үндэсний статистикийн хорооны дарга                          | 1                   | 2.00                  | 1        | 2.00                | 1             | 1.80     | 0.20    |
| Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд             | 59                  | 357.69                | 58       | 352.45              | 47            | 274.26   | 4.13    |
| Хууль зүй, дотоод хэргийн сайд                               | 6                   | 66.39                 | 5        | 36.77               | 5             | 24.46    | 12.31   |
| Хүний эрхийн үндэсний комиссын дарга                         | 1                   | 2.71                  | 1        | 2.71                | 1             | 2.27     | 0.44    |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд                  | 3                   | 11.40                 | 3        | 11.40               | 3             | 9.13     | 2.27    |
| Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга | 1                   | 2.41                  | 1        | 2.41                | 1             | 2.34     | 0.07    |
| Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд                | 3                   | 19.25                 | 3        | 19.25               | 2             | 12.85    | 5.20    |

|                                 |            |                 |            |                 |            |                 |               |
|---------------------------------|------------|-----------------|------------|-----------------|------------|-----------------|---------------|
| Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга | 6          | 68.19           | 6          | 68.19           | 6          | 56.35           | 11.85         |
| Шүүхийн сахилгын хороо          | 1          | 0.30            | 1          | 0.30            | 1          | 0.30            | -             |
| Эдийн засаг, хөгжлийн сайд      | 40         | 27.78           | 38         | 27.23           | 20         | 16.45           | (0.21)        |
| Эрүүл мэндийн сайд              | 21         | 108.69          | 19         | 100.73          | 6          | 35.04           | 7.90          |
| Эрчим хүчний сайд               | 10         | 282.58          | 10         | 282.58          | 10         | 265.70          | 16.88         |
| <b>Нийт</b>                     | <b>255</b> | <b>2,279.49</b> | <b>245</b> | <b>2,221.86</b> | <b>195</b> | <b>1,925.91</b> | <b>114.49</b> |

### Худалдан авах ажиллагааны төрөл:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс үзвэл 2025 онд нийт 20,433 төсөл, арга хэмжээний 6,476 буюу 31.7 хувь ажил, 10,966 буюу 53.7 хувь ажил, 2,991 буюу 14.6 хувь үйлчилгээ байна. Төсөвт өртгөөр үзвэл ажил 34,732.82 тэрбум төгрөг буюу 75.2 хувь, бараа 6,987.32 тэрбум төгрөг буюу 15.1 хувь, үйлчилгээ 4,490.60 тэрбум төгрөг буюу 9.72 хувийг тус тус эзэлж байна. Ажлын тоо хэмжээ төлөвлөгөөний 31.7 хувийг эзэлж байгаа боловч нөгөө талаас төсөв өртгийн 75.2 хувьтай тэнцүү байна.

Хэрэгжилтээр харвал нийт ажлын хувьд 63.9 хувь буюу 4,136 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч шалгарсан нь тухайн төсөвт өртгийн 34.5 хувь, барааны 70.0 хувь буюу 7,677 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч шалгарсан нь тухайн төсөвт өртгийн 72.5 хувь, үйлчилгээний 51.4 хувь буюу 1,538 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч шалгарсан нь төсөвт өртгийн 16.7 хувийг тус тус эзэлж байна.

Дээрх мэдээллээс үзэхэд барааны төрлийн тендер шалгаруулалт ажлын тендер шалгаруулалтаас хоёр дахин, үйлчилгээний тендер шалгаруулалтаас 4.5 дахин амжилттай болсон байна.

### Хүснэгт 19. Худалдан авах ажиллагааны хэрэгжилт, төрлөөр


| Төрөл       | Төлөвлөсөн    | ГБЭО          | Зөрүү /тоо/    | Харьцаа /тоо/ | Төлөвлөсөн төсөвт өртөг | ГБЭО ТАХ-ний төсөвт өртөг | Зөрүү /төсөвт өртөг/ | Харьцаа /төсөвт өртөг/ |
|-------------|---------------|---------------|----------------|---------------|-------------------------|---------------------------|----------------------|------------------------|
| Ажил        | 6,476         | 4,136         | (1,667)        | 63.9%         | 34,732.82               | 11,978.81                 | (12,732.05)          | 34.5%                  |
| Бараа       | 10,966        | 7,677         | (2,094)        | 70.0%         | 6,987.32                | 5,067.05                  | (493.19)             | 72.5%                  |
| Үйлчилгээ   | 2,991         | 1,538         | (1,088)        | 51.4%         | 4,490.60                | 748.10                    | (228.78)             | 16.7%                  |
| <b>Нийт</b> | <b>20,433</b> | <b>13,351</b> | <b>(4,849)</b> | <b>65.3%</b>  | <b>46,210.74</b>        | <b>17,793.96</b>          | <b>(13,454.02)</b>   | <b>38.5%</b>           |

Тайлант хугацаанд 15,584 тендер шалгаруулалт зарлаж, 13,351 тендер шалгаруулалтад гэрээ байгуулах эрх олгосон бол 2,233 тендер шалгаруулалт зарлагдсан бөгөөд зарласан тендер шалгаруулалтын 14 хувьд үр дүн гараагүй, амжилтгүй болсон байна. Үүнийг худалдан авах ажиллагааны төрлөөр ангилбал 673 ажил, 1,195 бараа, 365 үйлчилгээ байна. Үр дүн гараагүй, амжилтгүй болсон тендер шалгаруулалтын 53.5%-ийг барааны тендер шалгаруулалт эзэлж байна.

Зарласан хугацаагаар үзвэл ажлын тендер шалгаруулалтын 23.2 хувийг нэгдүгээр улиралд, 54.2 хувийг хоёрдугаар улиралд, 13.4 хувийг гуравдугаар улиралд, 9.2 хувийг дөрөвдүгээр улиралд зарласан; барааны тендер

шалгаруулалтын 32.9 хувийг нэгдүгээр улиралд 38.4 хувийг хоёрдугаар улиралд, 15.8 хувийг гуравдугаар улиралд, 12.7 хувийг дөрөвдүгээр улиралд зарласан; үйлчилгээний тендер шалгаруулалтын 19.3 хувийг нэгдүгээр улиралд, 46.2 хувийг хоёрдугаар улиралд, 18.6 хувийг гуравдугаар улиралд, 15.8 хувийг дөрөвдүгээр улиралд зарласан байна.

**Зураг 16. ТШ зарласан байдал, сараар**



Тайлант хугацаанд нийт 15,584 тендер шалгаруулалт зарлахад давхардаагүй тоогоор 7,739 иргэн, аж, ахуйн нэгж оролцож, 5,236 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гэрээ байгуулах эрх авч шалгарсан байгаа бол 2,503 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага огт шалгарч чадаагүй байна. Гэрээ байгуулах эрх аваагүй буюу нэг ч тендер шалгаруулалтад шалгараагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллага 32 хувийг эзэлж байна.

**Хүснэгт 20. ТШ зарласан байдал, төрлөөр**

| Төрөл       | Зарласан<br>ТАХ-ний<br>тоо | ГБЭО<br>буюу<br>амжилттай<br>ТАХ-ний<br>тоо | Зарласан<br>боловч<br>амжилтгүй<br>ТАХ-ний<br>тоо | Зарлагдаагүй<br>ТАХ-ний тоо | Нийт<br>оролцогч<br>/давхардаагүй | Шалгарсан<br>оролцогч<br>/давхардаагүй/ | Нэг ч ТШ-д<br>шалгараагүй<br>оролцогч<br>/давхардаагүй/ |
|-------------|----------------------------|---------------------------------------------|---------------------------------------------------|-----------------------------|-----------------------------------|-----------------------------------------|---------------------------------------------------------|
| <b>2024</b> |                            |                                             |                                                   |                             |                                   |                                         |                                                         |
| Ажил        | 6,555                      | 5,610                                       | 945                                               | 2,396                       | 3,269                             | 2,308                                   | 961                                                     |
| Бараа       | 8,935                      | 7,686                                       | 1,249                                             | 2,304                       | 4,534                             | 2,971                                   | 1,563                                                   |
| Үйлчилгээ   | 1,504                      | 1,257                                       | 247                                               | 934                         | 1,359                             | 888                                     | 471                                                     |
| <b>Нийт</b> | <b>16,994</b>              | <b>14,553</b>                               | <b>2,441</b>                                      | <b>5,634</b>                | <b>7,298</b>                      | <b>5,227</b>                            | <b>2,071</b>                                            |



| 2025        |               |               |              |              |              |              |              |
|-------------|---------------|---------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|
| Ажил        | 4,809         | 4,136         | 673          | 1,667        | 3,194        | 2,064        | 1,130        |
| Бараа       | 8,872         | 7,677         | 1,195        | 2,094        | 4,813        | 3,024        | 1,789        |
| Үйлчилгээ   | 1,903         | 1,538         | 365          | 1,088        | 1,627        | 984          | 643          |
| <b>Нийт</b> | <b>15,584</b> | <b>13,351</b> | <b>2,233</b> | <b>4,849</b> | <b>7,739</b> | <b>5,236</b> | <b>2,503</b> |

Худалдан авах ажиллагааны төрлөөр ангилж үзвэл 2025 онд зарласан ажлын 673 тендер шалгаруулалт амжилтгүй, үр дүн гараагүй байхад ажлын гэрээ байгуулах эрх аваагүй оролцогч 1,130, барааны 1,195 тендер шалгаруулалт амжилтгүй, үр дүн гараагүй байхад барааны гэрээ байгуулах эрх аваагүй оролцогч 1,789, үйлчилгээний 365 тендер шалгаруулалт амжилтгүй, үр дүн гараагүй байхад үйлчилгээний гэрээ байгуулах эрх аваагүй оролцогч 643 байсан байна.

• **Худалдан авах ажиллагааны арга:**


Төлөвлөгөөг худалдан авах ажиллагааны аргаар ангилбал 44,811.59 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 9,216 тендер шалгаруулалтыг нээлттэй аргаар, 621.93 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10,315 тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар, 643.61 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 261 тендер шалгаруулалтыг нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар, 133.61 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 641 тендер шалгаруулалтыг гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулахаар тусгасан байна.

Төсөвт өртгөөр авч үзвэл 96.8%-ийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 1.35%-ийг харьцуулалтын аргаар, 1.39 хувийг нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар, 0.29%-ийг гэрээ шууд байгуулах аргаар явуулахаар төлөвлөсөн байна. Тоо хэмжээгээр үзвэл 45.10%-ийг нээлттэй тендер шалгаруулалтын арга, 50.48%-ийг харьцуулалтын арга, 1.28%-ийг нэг эх үүсвэрээс худалдан авах арга, 3.14%-ийг гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхээр заасан байна.

Үүнээс тайлант хугацаанд нээлттэй аргаар 17,352.23 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6,478 тендер шалгаруулалт, харьцуулалтын аргаар 432.45 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6,859 тендер шалгаруулалт, нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар 2.39 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3 тендер шалгаруулалт, гэрээ шууд байгуулах аргаар 11.77 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 тендер шалгаруулалт тус тус зохион байгуулсан байна.



**Зураг 17. ТШ-ын хэрэгжилт, аргаар**



Дээрх зурагаас харвал нийт гэрээ байгуулах эрх олгосон 13,351 тендер шалгаруулалтаас 13,337 буюу 99.9 хувь, төсөвт өртгийн 17,793.96 тэрбум төгрөг 17,784.68 буюу 99.9 хувь өрсөлдөөнийг дэмжсэн худалдан авах ажиллагааны аргаар зохион байгуулагдсан байна.

Цахим системээр 2025 онд зохион байгуулсан 15,584 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох хүрээнд тендер шалгаруулалт явуулах тухай 26,149 зарлал нийтлэгдсэн нь төсөл, арга хэмжээний тооноос 68%-аар өндөр байна. Тус үзүүлэлт 2024 онд 85%-тай байсан бөгөөд 2025 онд төсөл, арга хэмжээний тоо, зарлалын тооны харьцаа 17%-аар буурсан нь төсөл, арга хэмжээний дахин зарлагдсан байдал багасаж буйг харуулж байгаа боловч зарим тендер шалгаруулалт олон удаа дахин зарлагдаж, анхны зарлал амжилтгүй болсныг илэрхийлж байна.

Цахим системд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 7,475 тендер шалгаруулалт явуулахад 11,849 удаа зарлал, харьцуулалтын аргаар 8,034 тендер шалгаруулалтад явуулахад 14,165 зарлал, гэрээ шууд байгуулах аргаар 26 тендер шалгаруулалт явуулахад 30 зарлал, нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар 12 тендер шалгаруулалт явуулахад 24 зарлал тус тус нийтлэгдсэн байна.

| Хүснэгт21 . ТШ зарласан байдал, дундаж, төрлөөр |                    |                  |                               |                    |                  |                               |
|-------------------------------------------------|--------------------|------------------|-------------------------------|--------------------|------------------|-------------------------------|
| Аргын нэр                                       | Зарласан ТШ-ын тоо | Нийтэлсэн зарлал | Нэг ТШ-д ногдох дундаж зарлал | Зарласан ТШ-ын тоо | Нийтэлсэн зарлал | Нэг ТШ-д ногдох дундаж зарлал |
| Он                                              | 2024 он            |                  |                               | 2025 он            |                  |                               |
| 1.Нээлттэй тендер шалгаруулалтын арга           | 8,529              | 14,570           | 1.7                           | 7,475              | 11,849           | 1.6                           |
| 2.Харьцуулалтын арга                            | 8,411              | 16,714           | 1.9                           | 8,034              | 14,165           | 1.8                           |
| 3.Гэрээ шууд байгуулах арга                     | 25                 | 58               | 2.3                           | 26                 | 30               | 1.2                           |
| 4.Нэг эх үүсвэрээс худалдан авах арга           | 4                  | 6                | 1.5                           | 12                 | 24               | 2.0                           |
| Нийт                                            | 16,994             | 31,410           | 1.8                           | 15,584             | 26,149           | 1.7                           |

Хүснэгтээс 2024, 2025 оны нэг тендер шалгаруулалтад ногдох дундаж зарлалын тоог харьцуулбал нээлттэй тендер шалгаруулалтын арга 1.7-оос 1.6, харьцуулалтын арга 1.9-ээс 1.8, бүх аргын хувьд 1.8-аас 1.7 болж буурсан төлөв ажиглагдсан, өөрөөр хэлбэл дахин зарлагдах давтамж 0.1 хувиар буурсан байна.

**Зураг 18.** Оролцогчдоос ирүүлсэн тендер, үр дүн




Нээлттэй болон харьцуулалтын аргаар нийт 15,509 тендер шалгаруулалт зарлахад 7,739 оролцогчоос 65,937 тендер ирүүлсэн байна. Үүнээс 22,470 тендерт гэрээ байгуулах эрх олгож (ГБЭО), 42,890 тендерээс татгалзсан байна. Нээлттэй тендер шалгаруулалтад 45,368 тендер ирснээс 14,189-д гэрээ байгуулах эрх олгож, 30,858-аас татгалзсан; харьцуулалтын тендер шалгаруулалтад 20,569 тендер ирснээс 8,281-д гэрээ

байгуулах эрх олгож, 12,032-оос татгалзсан байна.

Нийт тендер шалгаруулалтад ирж буй тендерийн дундаж буюу оролцогчийн дундаж 2025 онд 3.5, 2024 онд 3.0 байх бөгөөд оролцогчийн тоо 0.5-аар нэмэгдсэн байна. Худалдан авах ажиллагааны аргаар авч үзвэл нээлттэй тендер шалгаруулалтын дундаж оролцогч 4.7, харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын дундаж оролцогч 2.2 байна.

**Зураг 19.** Оролцогчийн дундаж




- Худалдан авах ажиллагааны гомдол:**

Тайлант хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт заасны дагуу зарласан нийт тендер шалгаруулалтын 10 хувь буюу 1,557 төсөл, арга хэмжээтэй

холбоотой оролцогчдоос гаргасан 2,284 гомдлыг<sup>3</sup> Сангийн яам хянан шийдвэрлэсэн байна. Харин хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэг<sup>4</sup>, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт<sup>5</sup> тус тус заасны дагуу тайлант хугацаанд оролцогчдоос 405 төсөл, арга хэмжээтэй холбоотой гомдол гаргасныг Монополын эсрэг газар хянан шийдвэрлэсэн байгаа бол Захиргааны хэргийн Анхан шатны шүүхэд 107 төсөл, арга хэмжээтэй холбоотой 114 нэхэмжлэл гаргасан байна.

**Зураг 20.** Гомдол гаргасан төсөл, арга хэмжээний тоо



**Захиргааны хэргийн Анхан шатны шүүх, Монополын эсрэг газарт гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн байдал:**

Тайлант хугацаанд Захиргааны хэргийн Анхан шатны шүүхэд нийт 114 нэхэмжлэл гаргаснаас 22 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 11 нэхэмжлэлийг буцаасан байна. Харин 87 хэргийг хүлээн авч, 12 хэрэг хянан шийдвэрлэгдэх ажиллагаанд байна. (Хүснэгт 22.)

| <b>Хүснэгт 22. ТШ-тай холбоотой Захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн маргааны тоо, оноор</b> |      |      |      |      |      |      |
|------------------------------------------------------------------------------------------------|------|------|------|------|------|------|
| Он                                                                                             | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
| <b>НИЙТ ГОМДОЛ, МАРГААН</b>                                                                    | 73   | 63   | 59   | 62   | 122  | 114  |
| <b>Үүнээс: УТХО-ын төсөл, арга хэмжээний гомдол, маргаан</b>                                   | 6    | 16   | 16   | 8    | 24   | 6    |
| <b>Үүнээс:</b>                                                                                 |      |      |      |      |      |      |
| • Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан                                                         | 4    | 2    | 2    | -    | 6    | 28   |
| • Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон                                                  | 2    | 11   | 13   | 6    | 8    | 46   |
| • Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан                                               | -    | 2    | 1    | -    | 1    | 5    |
| • Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан                                                   | -    | 1    | -    | 2    | 9    | 9    |

Тайлант хугацаанд Монополын эсрэг газарт нийт 503 гомдол гаргаснаас 414 буюу 82 хувь нь хууль зөрчсөн гэж шийдвэрлэгдсэн бол 79 буюу нийт гомдлын 16 хувийг хууль зөрчөөгүй гэж шийдвэрлэсэн байна.

### **Сангийн яаманд гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн байдал:**

Цахим системд бүртгэлтэй 7,739 оролцогчоос 1,266 нь 2025 онд Сангийн яаманд гомдол гаргасан нь нийт бүртгэлтэй оролцогчдын 16.4 хувийг эзэлж байна. 2024 онтой харьцуулж үзвэл цахим системд бүртгэлтэй оролцогчдын тоо 7,298-аас 7,739 болж 6 хувиар өссөн бол Сангийн яаманд гомдол гаргасан оролцогчдын тоо 1,098-аас 1,266 болж 15.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

- Тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг захиалагчийн ангиллаар авч үзвэл 2025 оны байдлаар төрийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зохион байгуулсан тендер шалгаруулалтын 17.7 хувьд гомдол гарсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа бол нийслэл 10.1 хувь, Засгийн газрын харьяа байгууллага 9.1 хувь, бусад төсвийн байгууллага 9.3 хувь, аймгийн захиалагчдын 6.9 хувьд тус тус гомдол гарсан байна.

Дээрх үзүүлэлтийг 2024 онтой харьцуулахад төрийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гомдлын эзлэх хувь 15.1 хувиас 17.7 хувь болж өссөн, нийслэлийн захиалагчдын хувьд 9.0 хувиас 10.1 хувь болж нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Харин аймаг болон зарим төсвийн байгууллагын хувьд оролцогчдоос гаргасан гомдлын хувь буурсан үзүүлэлттэй байна.

Нийт дүнгээр авч үзвэл 2024 онд нийт тендер шалгаруулалтын 9.4 хувьд гомдол гарч байсан бол 2025 онд 10.0 хувь болж өссөн байгааг харуулж байна (Хүснэгт 23).

| <b>Хүснэгт 23. Гомдлын харьцаа</b> |                 |                      |                |                 |                      |                |
|------------------------------------|-----------------|----------------------|----------------|-----------------|----------------------|----------------|
| <b>Он</b>                          | <b>2024</b>     |                      |                | <b>2025</b>     |                      |                |
| <b>Захиалагч</b>                   | <b>Зарласан</b> | <b>Гомдол гарсан</b> | <b>Харьцаа</b> | <b>Зарласан</b> | <b>Гомдол гарсан</b> | <b>Харьцаа</b> |
| Аймаг                              | 5,606           | 425                  | 7.6%           | 4,916           | 341                  | 6.9%           |
| Бусад ТЕЗ                          | 583             | 38                   | 6.5%           | 589             | 55                   | 9.3%           |
| Засгийн газар                      | 6,055           | 542                  | 9.0%           | 5,577           | 508                  | 9.1%           |
| Нийслэл                            | 2,113           | 191                  | 9.0%           | 1,902           | 193                  | 10.1%          |
| Төрийн өмчийн болон оролцоотой     | 2,637           | 398                  | 15.1%          | 2,600           | 460                  | 17.7%          |
| <b>Нийт</b>                        | <b>16,994</b>   | <b>1,594</b>         | <b>9.4%</b>    | <b>15,584</b>   | <b>1,557</b>         | <b>10.0%</b>   |


Тайлант хугацаанд оролцогчдоос тендер шалгаруулалттай холбогдуулан Сангийн яаманд гаргасан нийт 2,284 гомдлыг хянан шийдвэрлэснээс 1,773 гомдол нь үндэслэлтэй, 511 гомдол нь үндэслэлгүй буюу захиалагчийн шийдвэр үндэслэлтэй гэсэн шийдвэр гарсан. Харин 2024 онд нийт 2,178 гомдол хянан шийдвэрлэснээс 1,755 гомдол нь үндэслэлтэй, 423 гомдол нь үндэслэлгүй гэсэн шийдвэр гарсан байна (Хүснэгт 24).

#### Хүснэгт 24. Хянан шийдвэрлэсэн гомдол, гомдол гаргасан оролцогчдын тоо, оноор

| Он   | Шийдвэрлэсэн гомдол | Гомдол үндэслэлтэй | Гомдол үндэслэлгүй | Бүртгэлтэй оролцогч | Гомдол гаргасан оролцогч |
|------|---------------------|--------------------|--------------------|---------------------|--------------------------|
| 2024 | 2,178               | 1,755              | 423                | 7,739               | 1,098                    |
| 2025 | 2,284               | 1,773              | 511                | 7,298               | 1,266                    |

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2025 онд 245 тендер шалгаруулалт зарласнаас 24.9 хувь буюу 61-д нь гомдол гарсан байна.

#### Зураг 21. Гомдлын шийдвэр, 2025 он




Түүнчлэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална: 13.1.1. батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах; 13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах

ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох” гэж заасны дагуу захиалагчид санхүүжилтийн эх үүсвэрийг төсвийн хэмнэлтэд тооцож, гэрээ байгуулахгүй байх талаар мэдэгдэж ажилласан .

Оролцогчдоос Сангийн яаманд гаргасан гомдлыг ангиллаар авч үзвэл хуулийн 12 дугаар зүйлд заасан бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт, 17 дугаар зүйлд заасан туршлагын шаардлага болох ижил төстэй бараа, ажил, үйлчилгээний гэрээний мэдээлэлтэй холбоотой асуудлаар голчлон Сангийн яаманд хандсан байна.

**Зураг 22.** Оролцогчдоос гаргасан гомдлын ангилал




Бусад ангиллын хувьд хуулийн 7 дугаар зүйлд заасан оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг, 16 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, 17 дугаар зүйлд заасан гэрээний үүргийг гүйцэтгэхтэй холбоотой машин механизм, тоног төхөөрөмж, хүний нөөц зэрэг асуудал хамаарч байна.

• **Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтын талаар:**

Төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч, оролцогчоос ирүүлсэн гомдол, хүсэлтэд үндэслэн 2025 онд Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагч 3 удаа удирдамж баталж, нийт 43 хуулийн этгээдтэй холбоотойгоор хяналт шалгалтын ажиллагаа явуулсан.

Үүнээс хуурамч бичиг баримттай холбоотой 35, худалдан авах гэрээний үүргийн зөрчилтэй холбоотой 8 хуулийн этгээдтэй холбогдуулж худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүгнэлт гарч, 20 хуулийн этгээдийг Сангийн сайдын тушаалаар тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарласан.

**Зураг 23.** Эрхээ хязгаарлуулах болсон үндэслэл




Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад нийт 124 хуулийн этгээд бүртгэлтэй байна. Үүнээс 74 хуулийн этгээд худалдан авах гэрээний үүрэг биелүүлээгүй бол, 50 хуулийн этгээд илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснээр

тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн байна.

- **Тендерийн баталгааны талаар:**

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт заасны дагуу оролцогч тендерийн баталгаа<sup>6</sup> банкны, эсхүл Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасны баталгаагаар, эсхүл Монгол Улсын даатгагчаас гаргасан баталгаагаар гаргадаг.

**Зураг 24. Баталгааны дүн, оноор (тэрбум төгрөг)**



Цахим системийн мэдээллээс үзэхэд тайлант хугацаанд оролцогчдоос гаргасан тендерийн баталгааны дүн 418.2 тэрбум төгрөг байгаагаас банкны баталгаа 388.9 тэрбум төгрөг, даатгагчийн баталгаа 29.2 тэрбум төгрөгийг тус тус эзэлж байна. Үүнийг 2024 онтой харьцуулахад нийт оролцогчдоос гаргасан баталгааны дүн

33 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Банкны баталгааны тоо 2025 онд 7.6 хувиар буурсан хэдий ч баталгааны дүн 388.9 тэрбум төгрөгт хүрч 2024 онд гаргасан 267.2 тэрбум төгрөгөөс 45.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Оролцогчдоос Сангийн яаманд гаргасан гомдлыг хянан шийдвэрлэж, гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэснээр тендерийн баталгааг улсын орлого болгосон дүн 2024 онд 1.3 тэрбум буюу нийт оролцогчдоос гаргасан баталгааны 0.47 хувь, 2025 онд 1.7 тэрбум төгрөг буюу нийт оролцогчдоос гаргасан баталгааны 0.41 хувийг тус тус эзэлж байна.



## 1.7. НЭМЭЛТ ТӨСӨВ

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасан нэмэлт төсвийг 2025 онд бүрдүүлэн холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн нийт эх үүсвэр 2025 онд 982.5 тэрбум төгрөг төвлөрөн, 584.4 тэрбум төгрөг буюу 59.5 хувийг төсвийн эх үүсвэрээс, 398.1 тэрбум төгрөг буюу 40.5 хувийг төсвийн бус эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

Эх үүсвэрийг ангилан үзэхэд:

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 320.3 тэрбум төгрөг;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 66.2 тэрбум төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 318.9 тэрбум төгрөг;
- Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 264.0 тэрбум төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос 7.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд нэмэлт төсвөөр 876.7 тэрбум төгрөгийн зарцуулалт гарсан байна. Нийт зарлагын гүйцэтгэлийг сайдын багцаар авч үзвэл:

Нийслэл Улаанбаатар хот 206.9 тэрбум төгрөг, Батлан хамгаалахын сайд 121.7 тэрбум төгрөг, Хууль зүй, дотоод хэргийн сайд 104.8 тэрбум төгрөг, Монгол Улсын Шадар сайд 48.2 тэрбум төгрөгийг зарцуулсан нь нийт зарцуулалтад голлон нөлөөлсөн байна.

Нэмэлт төсвийн нийт зарлагыг эдийн засгийн ангиллаар нь түүвэрлэн авч үзвэл:

Бараа үйлчилгээний бусад зардал 281.0 тэрбум төгрөг 32.1 хувийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 193.6 тэрбум төгрөг 22.1 хувийг, хөрөнгийн зардал 86.4 тэрбум төгрөг 9.8 хувийг, цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардал 84.9 тэрбум төгрөг 9.6 хувийг, томилолтын зардал 52.3 тэрбум төгрөг 6.0 хувийг тус тус эзэлж байна.

## 1.8. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ, ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болох Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв хүрсэн үр дүнгийн тайланг тайлагнах эрх зүйн актыг 2023 оны 12 дугаар сард Сангийн сайдын 225 тоот тушаалаар батлуулсан. Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн системийн бүрэлдэхүүн “Хөтөлбөр, үр дүнгийн тайлан”-ийн хэсгийг хөгжүүлж 2025 оны жилийн эцсийн тайланд нэгтгэлийг системээр гүйцэтгэсэн.

**Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:** Улсын төсвийн нийт 36 төсвийн ерөнхийлөн захирагчдын 99 хөтөлбөрийн нийт 486 шалгуур үзүүлэлт батлагдсан. Төсвийн ерөнхийлөн захирагч дунджаар 3 шалгуур үзүүлэлттэй ба 10 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлттэй 12 төсвийн ерөнхийлөн захирагч байна. Шалгуур үзүүлэлтийн тоо хөтөлбөр болон хүрэх үр дүнгийн тоо нь батлагдсан төсвийн хэмжээтэй хамааралтай байна.

Хөтөлбөр үр дүнгийн тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр гарган төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн.

## 2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улсын 2025 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 19,550.5 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 20,414.3 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцэл 1,426.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

### 2.1. УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2025 онд 19,550.5 тэрбум төгрөгт хүрч, 96.7 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөнөөс 673.6 тэрбум төгрөг дутуу, өмнөх оны гүйцэтгэлээс 982.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 25. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл /тэрбум төгрөг/**

| ҮЗҮҮЛЭЛТ                                            | 2025 оны        |                 |              |                |
|-----------------------------------------------------|-----------------|-----------------|--------------|----------------|
|                                                     | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Хувь         | Зөрүү          |
| <b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>                | <b>20,224.1</b> | <b>19,242.5</b> | <b>95.1</b>  | <b>981.6</b>   |
| <b>ИРЭЭДҮЙН ӨВ САН</b>                              | <b>0.0</b>      | <b>0.0</b>      | <b>0.0</b>   | <b>0.0</b>     |
| <b>ХУРИМТЛАЛЫН САН</b>                              | <b>0.0</b>      | <b>0.0</b>      | <b>0.0</b>   | <b>0.0</b>     |
| <b>ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН</b>                         | <b>429.1</b>    | <b>562.5</b>    | <b>131.1</b> | <b>-133.4</b>  |
| <b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b> | <b>19,795.0</b> | <b>18,680.0</b> | <b>94.4</b>  | <b>1,115.0</b> |
| <b>1. Татварын орлого</b>                           | <b>16,499.6</b> | <b>15,611.1</b> | <b>94.6</b>  | <b>887.5</b>   |
| Орлогын албан татвар                                | 3,835.5         | 3,771.1         | 98.3         | 64.4           |
| <i>ААН-ын орлогын албан татвар</i>                  | 3,835.5         | 3,771.1         | 98.3         | 64.4           |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар                      | 6,646.8         | 6,207.3         | 93.4         | 439.5          |
| Онцгой албан татвар                                 | 1,254.5         | 949.0           | 75.6         | 305.5          |
| Тусгай зориулалтын орлого                           | 31.5            | 25.5            | 80.9         | 6.0            |
| Гадаад үйл ажиллагааны орлого                       | 2,114.0         | 1,842.2         | 87.1         | 271.8          |
| Бусад татвар, төлбөр, хураамж                       | 2,617.2         | 2,816.0         | 107.6        | -198.8         |
| <b>2.Татварын бус орлого</b>                        | <b>3,295.4</b>  | <b>3,375.9</b>  | <b>102.4</b> | <b>-80.5</b>   |
| Нийтлэг татварын бус орлого                         | 1,070.8         | 1,216.4         | 163.0        | -674.5         |
| Тусламжийн орлого                                   | 421.1           | 340.2           | 80.8         | 80.9           |
| Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг  | 1,803.5         | 1,290.4         | 71.5         | 513.1          |

Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 82.2 хувь татварын орлогоос, 17.8 хувь нь татварын бус орлогоос бүрдсэн байна.

Төсвийн орлогын чиглэлээр 2025 онд эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах, уул уурхайн биржийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зэрэг арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүллээ.

Уул уурхайн салбарын өсөлт жилийн хоёрдугаар хагаст сэргэснээр 10.6 хувьд хүрч, нийт эдийн засгийн өсөлтийн 1.4 хувийг бүрдүүлэв. Уул уурхайн салбар оны эхний хагаст 1.1 хувийн өсөлттэй байсан бол нүүрсний экспортын хэмжээ нэмэгдсэнээр сэргэж 4 дүгээр улиралд 95.5 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өслөө.

Түүнчлэн зэсийн баяжмал үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 36 хувиар, тухайлбал, Оюу толгойн гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр оны эхний гурван улиралд 42.2 хувиар өссөн нь уул уурхайн салбарын өсөлтийг дэмжив. Мөн төмрийн хүдрийн үйлдвэрлэлийн өсөлт хадгалагдаж 8.8 сая тоннд хүрснээр өмнөх оны мөн үеэс 31.8 хувиар өслөө. Алтны олборлолт 11 улирал дараалан буурч байснаас сэргэж 2025 оны 4 дүгээр улиралд 13.1 тоннд хүрч, 4.1 хувиар өссөн. Харин газрын тос олборлолт 8 улирал дараалан буурч 3.8 сая тонн болсноор уул уурхайн салбарын өсөлтийг сааруулсан байна.

Хөдөө аж ахуйн салбар 33.2 хувиар өсөж нийт эдийн засгийн өсөлтийн 2.9 хувийг бүрдүүллээ. Бойжсон төлийн тоо толгой 21.7 саяд хүрч (төл бойжилт 96.5 хувь) өмнөх оны мөн үеэс 5.5 сая толгой малаар нэмэгдэж, том малын зүй бус хорогдол 359 мянга болж, өмнөх оны мөн үеэс 9 сая толгой малаар буурснаар хөдөө аж ахуйн салбарын 90 орчим хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн салбарын өсөлт өндөр гарлаа. Харин газар тариалангийн салбарын хувьд оны эхний хагаст тариалангийн гол бүс нутгаар олон жилийн дунджаас бага хур тунадас унаснаар нийт хураасан үр тариа өмнөх оноос 148.6 мянган тонн, төмс 137.3 мянган тонн, хүнсний ногоо 42.5 мянган тонн, тэжээлийн ургамал 61 мянган тонноор тус тус буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын өсөлт эрчимжлээ. Боловсруулах салбарын өсөлт эрчимжиж, 2025 онд 10 хувиар өслөө. Үүнд төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл боловсруулах салбарын өсөлтийг голлон дэмжсэн байна. Эрчим хүчний салбар 2025 онд 10.2 хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийн 0.2 нэгж хувийг бүрдүүлэв. Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 9.6 тэрбум кВт цагт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар, дулааны эрчим хүч үйлдвэрлэл 17.3 сая Гкал-д хүрч, 8.5 хувиар нэмэгдэн эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн өсөлт тогтвортой хадгалагдлаа. Үүнд, шинээр ашиглалтад орсон Тосон, Бөөрөлжүүт зэрэг ДЦС-уудын үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөллөө. Барилгын салбарын өсөлтийг Улаанбаатар хот дахь эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламж болон Багахангай-Хөшгийн хөндий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлууд, Сэлэнгэ аймаг дахь 70 МВт хүчин чадал бүхий дулааны цахилгаан станц, Дорнод аймгийн авто замын бүтээн байгуулалтын ажлууд зэрэг нь үргэлжлүүлэн тэтгэснээр 2025 онд 15.9 хувиар өслөө.

Тээврийн салбар 2025 онд 4.8 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 0.3 нэгж хувийг бүрдүүлэв. Зам, тээврийн салбар 2025 онд бүх төрлийн тээврээр нийт 146.4 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос 10.3 хувиар нэмэгдсэн бөгөөд төмөр замын ачаа тээвэр 50 сая тоннд хүрч 8.7 хувиар, авто замын ачаа тээвэр 96.5 сая тоннд хүрч 10 хувиар, агаарын тээврийн ачаа 12.5 мянган тоннд хүрч 20 хувиар тус тус нэмэгдсэн нь өсөлтөд нөлөөллөө. Нийт ачаа тээврийн 65.9 хувийг авто тээвэр, 34.1 хувийг төмөр замын тээвэр, 0.01 хувийг агаарын тээврийн ачаа эзэлж байна.

## 2.2. УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2025 онд 20,414.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 2,150.0 тэрбум төгрөг буюу 9.5 хувиар бага гарсан байна.

Улсын төсвийн урсгал зардалд 16,706.7 тэрбум, хөрөнгийн зардалд 3,759.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

### Хүснэгт 27. Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ                                          | 2025 он         |                 |              |                 |
|---------------------------------------------------|-----------------|-----------------|--------------|-----------------|
|                                                   | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Хувь         | Зөрүү           |
| <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>          | <b>22,564.3</b> | <b>20,414.3</b> | <b>90.5</b>  | <b>-2,150.0</b> |
| <b>НИЙТ ЗАРЛАГА</b>                               | <b>22,564.3</b> | <b>20,414.3</b> | <b>90.5</b>  | <b>-2,150.0</b> |
| УРСГАЛ ЗАРДАЛ                                     | 17,983.8        | 16,706.7        | 92.9         | -1,277.1        |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                   | 5,662.0         | 5,482.1         | 96.8         | -179.9          |
| ХҮҮ                                               | 1,292.9         | 1,208.9         | 93.5         | -84.0           |
| ТАТААС                                            | 2,027.3         | 1,826.2         | 90.1         | -201.1          |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                  | 5,743.6         | 5,476.8         | 95.3         | -266.8          |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ                                  | 4,707.4         | 3,759.9         | 79.9         | -947.5          |
| <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b> | <b>-126.9</b>   | <b>-52.3</b>    | <b>315.5</b> | <b>41.2</b>     |

Улсын төсвөөс Нийгмийн даатгалын санд 1,452.5 тэрбум төгрөгийн татаас, орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 273.3 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн санд хуваарилах орлогын шилжүүлгээр 411.7 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Гадаад зээлийн үйлчилгээний зардалд 1,173.3 тэрбум төгрөг, дотоод зээлийн үйлчилгээний зардалд 35.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### Хүснэгт 28. Бараа, ажил, үйлчилгээний зардлын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ                                                 | 2025 он        |                |             |                |
|----------------------------------------------------------|----------------|----------------|-------------|----------------|
|                                                          | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | Хувь        | Зөрүү          |
| <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                   | <b>8,920.0</b> | <b>8,194.8</b> | <b>91.9</b> | <b>(725.2)</b> |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 5,662.1        | 5,482.1        | 96.8        | (180.0)        |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 555.0          | 535.5          | 96.5        | (19.5)         |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 212.6          | 178.3          | 83.7        | (34.3)         |
| Хангамж, бараа материалын зардал                         | 97.6           | 83.6           | 85.7        | (13.9)         |
| Нормативт зардал                                         | 414.2          | 301.4          | 72.8        | (112.8)        |
| Эд хогшил, урсгал засварын зардал                        | 156.9          | 129.2          | 82.3        | (27.7)         |
| Томилот, зочны зардал                                    | 88.6           | 71.9           | 81.2        | (16.7)         |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,060.4        | 839.3          | 79.1        | (221.1)        |

|                                 |       |       |      |        |
|---------------------------------|-------|-------|------|--------|
| Бараа үйлчилгээний бусад зардал | 672.7 | 573.4 | 85.2 | (99.3) |
|---------------------------------|-------|-------|------|--------|

Улсын төсвөөс олгох татаасаар 1,826.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 201.2 тэрбум төгрөгөөр дутуу буюу 90.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### Хүснэгт 29. Татаас /тэрбум төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ                                  | 2025 он        |                |             |                |
|-------------------------------------------|----------------|----------------|-------------|----------------|
|                                           | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | Хувь        | Зөрүү          |
| <b>ТАТААС</b>                             | <b>2,027.3</b> | <b>1,826.2</b> | <b>90.1</b> | <b>(201.1)</b> |
| Төрийн өмчит байгууллагад олгох татаас    | 1,533.0        | 1,531.2        | 99.9        | (1.7)          |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 494.4          | 295.0          | 59.7        | (199.4)        |

#### Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас:

Хувийн хэвшлийн байгууллагад 2025 онд 494.4 тэрбум төгрөгийн татаас олгохоос 295.0 тэрбум төгрөгийн татаас олгож, гүйцэтгэл 59.7 хувьтай байна. Үүнд:

#### САНГИЙН ЯАМ

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолын дагуу хөдөө орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих зээлийн санхүүжилтэд 3 арилжааны банкаар дамжуулан 5 хүртэл жилийн хугацаатай 1.3 тэрбум төгрөгийн 1 хувийн хүүтэй зээлд 138.5 сая төгрөгийн татаас санхүүжилт олгосон байна.

Хувийн хэвшлийн байгууллагад 250.2 сая төгрөгийн татаас олгохоос 143.4 сая төгрөгийг олгосон.

#### ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүрээнд 2023, 2024, 2025 онд арилжааны 9 банкаар дамжуулан олгосон 1,428 зээлдэгчийн 525.9 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн татаасанд 51.9 тэрбум төгрөгийн хүүгийн татаас олгосон байна.

Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох хүрээнд 2024 онд олгосон 20164 малчны, 2025 онд олгосон 6226 малчны зээлд Засгийн газар хариуцан 59.4 тэрбум төгрөгийг хүүгийн хөнгөлөлт үзүүлсэн.

Цагаан Алт хөтөлбөрийн хүрээнд 170 зээлдэгчийн зээлийн хүүг Засгийн газар хариуцан хүүгийн татаас 15.7 тэрбум төгрөгийг төлсөн.

Атрын дөрөвдүгээр аяны хүрээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 801 зээлдэгчийн зээлийн хүүг Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн татааст 2.8 тэрбум төгрөг төлсөн.

Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци, Зээлийн батлан даалтын сангийн хооронд 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан "Үнэт цаас худалдах, худалдан авах, түүнд батлан даалт гарган санхүүжүүлэх" №12/02-02 гэрээний дагуу тус яамнаас 5.0 тэрбум төгрөгийн татаас олгосон.

### **ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

Хувийн хэвшлийн байгууллагад 2.9 тэрбум төгрөгийн татаас олгохоос 2.4 тэрбум төгрөгийг олгосон.

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-нд тусгасан "Хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих зээл"-д 2023-2024 оныг дуустал арилжааны 3 банкаар дамжуулан 70.6 тэрбум төгрөгийн 7 хувийн хүүтэй зээл олгож, Засгийн газраас олгох хүүгийн дэмжлэг олгосон байна.

### **СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

Хувийн хэвшлийн байгууллагад 1.6 тэрбум төгрөгийн татаас олгохоос 1.0 тэрбум төгрөгийг олгосон.

"Аялал жуулчлалыг салбарыг дэмжих зээл"-ийн зээлийн хүүгийн татаас санхүүжилтэд 1.2 тэрбум төгрөг батлагдсан. Тайлант онд арилжааны банкуудтай тооцоо нийлж 49 зээлдэгчид олгосон зээлийн хүүгийн дэмжлэг татаас санхүүжилтэд 0.7 тэрбум төгрөгийн олгосон.

Соёлийн салбарын хувийн хэвшлийн байгууллагуудад олгох татаас 0.4 тэрбум төгрөг төсөвлөгдөн, Уран харандаа улсын уралдаан, Фото вийк 2025 арга хэмжээ, Норд арт үзэсгэлэнд оролцох, Циркийн олон улсын Монте Карло уралдаанд оролцох гэх мэт хөгжмийн болон дүрслэх, дизайн, циркийн урлагийн 13 уралдаан, наадам зохион байгуулах, оролцоход дэмжлэг татаас 0.3 тэрбум төгрөгийг зарцуулсан.

### **ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

Хувийн хэвшлийн байгууллагад 1.3 тэрбум төгрөгийн татаас санхүүжилтийг олгосон.

Монголсат нэтворкс ХХК-тай 2019 онд байгуулсан Сансарын холбооны Кэй Юү зурвасын технологи ашиглан телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам INTELSAT ба REUTERS-ийн суваг ашигласны төлбөр буюу

“Монголсат нетворкс” ХХК-аар Сансрын холбооны Кэй юү зурвасын технологи ашиглан телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээний 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.

### **ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ**

Хувийн хэвшлийн байгууллагад 62.8 тэрбум төгрөгийн татаас олгохоос 43.5 тэрбум төгрөгийг олгосон.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолын 1 дэх заалтын дагуу Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон аймаг, сум, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг (Багануур, Багахангай)-т анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн 3 хувийн хүүтэй Хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаасд 43.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

#### **Төрийн өмчит байгууллагад олгох татаас:**

Төрийн өмчит байгууллагад 2025 онд 1.5 тэрбум төгрөгийн татаас олгохоос 1.5 тэрбум төгрөгийн татаас олгож гүйцэтгэл 99.9 хувьтай байна

### **БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ**

Төрийн өмчит байгууллагад 2025 онд 12.7 тэрбум төгрөгийн татаас олгосон.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Батлан хамгаалах яамны багцын урсгал зардалд “Цэргийн төв эмнэлэг” Тусгай эмнэлэгт олгох татаас – 10.6 тэрбум төгрөг, “Зэв” Улсын төсөвт үйлдвэрийн газарт олгох татаас - 2.1 тэрбум төгрөг батлагдсан.

### **ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

Төрийн өмчит байгууллагад 2025 онд 126.6 тэрбум төгрөгийн татаас олгосон.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Эрчим хүчний сайдын багцын урсгал зардалд 126.6 тэрбум төгрөгийн эрчим хүчний үйлдвэр компаниуд алдагдлын татаас, Өвлийн хүлэмж аж ахуй эрхлэгчдийн татаас, гэр хорооллын айл өрхийн шөнийн тарифын хөнгөлөлтийн татаас санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэл 126.6 тэрбум төгрөг байна. Татаас 44.2 тэрбум төгрөг, өвлийн хүлэмж, шөнийн тарифын хөнгөлөлт 82.4 тэрбум төгрөгийг тус тус олгосон.

### **ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

Төрийн өмчит байгууллагад 2025 онд 0.7 тэрбум төгрөгийн татаасыг бүрэн олгосон.

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төвийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор улсын



төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулж, төсвийн зардлыг 2021 оноос улсын төсөвт тусган санхүүжүүлсэн. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны багцын урсгал зардалд “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэр” ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалт бүхий 0.7 тэрбум төгрөгийн татаас олгосон.

### **САНГИЙН ЯАМ**

Төрийн өмчит байгууллагад 2025 онд 9.6 тэрбум төгрөгийн татаас олгосон.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Сангийн яамны багцын урсгал зардалд “Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз” Үндэсний олон нийтийн мэдээллийн үйл ажиллагааг дэмжих 9.6 тэрбум төгрөгийн татаас олгосон.

### **ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

Төрийн өмчит байгууллагад 2025 онд 5.2 тэрбум төгрөгийн татаас олгосон.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны багцын урсгал зардалд Радио шугам, хиймэл дагуул, VPN ашиглалт– 5.2 тэрбум төгрөг батлагдсан.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төрийн өмчийн хорооны 2015 оны 230 дугаар тогтоолын хүрээнд Төрийн өмчийн радио, телевизийн сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг дамжуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг Радио, телевизийн үндэсний сүлжээ улсын төсөвт үйлдвэрийн газарт олгосон. РТҮС УТҮГ нь Баян-Өлгий, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Хөвсгөл аймгийн салбаруудад санхүүжилт хуваарилж ажилладаг.

### **ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Төрийн өмчит байгууллагад 2025 онд 5.6 тэрбум төгрөгийн татаас олгохоос 5.3 тэрбум төгрөгийн татаас олгосон.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Хууль зүй, дотоод хэргийн яамны багцын урсгал зардалд “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн татаас” тусгай эмнэлэгт олгох татаас – 5.6 тэрбум төгрөг батлагдсан.

### **БОЛОВСРОЛЫН ЯАМ**

Төрийн өмчит байгууллагад 2025 онд 4.2 тэрбум төгрөгийн татаас олгосон.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Боловсролын яамны багцын урсгал зардалд “Монгол-Япон эмнэлэг” түшиц эмнэлэгт олгох татаас - 2.1 тэрбум төгрөг, Монгол-Германы хамтарсан технологийн дээд сургуульд олгох татаас -2.1 тэрбум төгрөг батлагдсан.

Татаасыг хөтөлбөрөөр нь авч үзвэл:

Мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд:

- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт: Боловсролын салбарын хэмжээнд 2022 оноос эхлэн хэрэгжсэн хүүхдийн тооноос хамаарсан гүйцэтгэлийн санхүүжилт нь багш, захиргаа, аж ахуйн ажилтны цалин, нийгмийн даатгалын шимтгэл, сургалтын хэрэглэгдэхүүн, хөдөлмөр хамгааллын хэрэглэл, дадлага ажлын материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл гэсэн чиглэлээр сургалтын байгууллагад олгогдож байна. Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагуудын албан хаагчдын цалингийн сан, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 105.7 тэрбум төгрөг, төрийн бус өмчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын хувьсах зардалд 15.4 тэрбум төгрөг, сургалтын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр 9.9 тэрбум төгрөг;
- МСҮТ-д суралцагсдад сар тутам олгох тэтгэлэг: Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 421 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2025 онд 49.1 тэрбум төгрөг;

*Дээд боловсролын хөтөлбөрийн хүрээнд:*

- Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг:  
Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгээр гадаадын их, дээд сургуульд суралцаж буй 961 суралцагчдад нийт 45.9 тэрбум төгрөг, дотоодын их, дээд сургуулийн бэлтгэл хөтөлбөрт 304 суралцагчдад 0.9 тэрбум төгрөг, нийт 1265 суралцагчдад 46.9 тэрбум төгрөг;
- Зарим суралцагч (нэн ядуу, малчин, 3 суралцагч)-дад олгох сургалтын төлбөрийн тэтгэлэг:  
Зорилтот бүлгийн суралцагчид олгох буцалтгүй тусламжид давхардсан тоогоор 412 боловсролын байгууллагын 2309 зорилтот бүлгийн суралцагчдад 2.3 тэрбум төгрөг;
- Гадаадад суралцагсдын зээл:  
Боловсрол шинжлэх ухааны сайдын 2020-2025 оны тушаалаар дэлхийн шилдэг их дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт 2025 онд 166 суралцагч 13.9 тэрбум төгрөг;
- Засгийн газрын тэтгэлэг:  
Монгол Улсын Засгийн газрын нэрэмжит тэтгэлгээр гадаадад эрэлттэй, тэргүүлэх мэргэжлээр магистр, докторын хөтөлбөрт суралцаж байгаа 44 суралцагчид 4.5 тэрбум төгрөг, дотоодын бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцаж байгаа 926 суралцагчид 2.3 тэрбум төгрөг нийт 970 суралцагчид 6.8 тэрбум төгрөг;
- Оюутан хөгжлийн зээл:  
Дотоодын их дээд сургуулиудад суралцагсдад олгосон сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлээр суралцаж байгаа 1033 суралцагчид 2.2 тэрбум төгрөг;
- Багш мэргэжлээр суралцагчид олгох тэтгэлэг:

Багш мэргэжлээр суралцагчид олгох тэтгэлгээр суралцаж байгаа 8093 суралцагчийн 22.6 тэрбум төгрөг;

## **ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

### **Нийгмийн бүлэгт чиглэсэн**

*Хүүхдэд чиглэсэн бодлогын хүрээнд:*

- Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 1,353,720 хүүхдэд 1,549.7 тэрбум төгрөг;
- Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны 17,237 хүүхдэд 79.0 тэрбум төгрөг;
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээгээр 51,774 хүүхдэд 3.6 тэрбум төгрөг;
- Цаатан иргэний тэтгэмжийг 158 хүүхдэд 510.0 сая төгрөг;

*Эхчүүдэд чиглэсэн бодлогын хүрээнд:*

- 0-3 хүртэлх насны хүүхэд асаргааны тэтгэмж 158,687 иргэнд 67.0 тэрбум төгрөг;
- Эхийн алдар одонгийн мөнгөн тусламжийг 270,258 эхчүүдэд 66.0 тэрбум төгрөг;
- Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид 9,049 иргэнд 22.9 тэрбум төгрөг;
- Жирэмсэн эхийн тэтгэмжийг 61,370 иргэнд 8.1 тэрбум төгрөг;
- Ихэр хүүхдийн тэтгэмжийг 649 эх, эцгүүдэд 1.3 тэрбум төгрөг;

*Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлогын хүрээнд:*

- Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн 36,166 иргэнд 163.5 тэрбум төгрөг;
- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 16,054 иргэнд 3.1 тэрбум төгрөг, асарч байгаа 17,899 иргэнд 52.9 тэрбум төгрөг;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжид 51,390 иргэнд 12.3 тэрбум төгрөг;

*Ахмадуудад чиглэсэн бодлогын хүрээнд:*

- Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа 46,092 иргэнд 129.5 тэрбум төгрөг;
- НДС-аас өндөр настны тэтгэвэр авах эрх үүсээгүй 7,972 ахмадуудад 34.3 тэрбум төгрөг;
- Насны хишиг тэтгэмжийг 65-аас дээш насны 204,755 иргэнд 30.5 тэрбум төгрөг;
- Амралт, сувиллын газрын эрхийн бичгийн үнийн хөнгөлөлтийг 60,973 иргэнд 15.6 тэрбум төгрөг;
- Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг 37,479 иргэнд 6.0 тэрбум төгрөг;
- Байнгын асаргаа шаардлагатай 44,363 ахмад настанд 8.5 тэрбум төгрөг;

## Гадаад зээл, тусламж:

Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэхээр нийт 102 төсөл, арга хэмжээнд 1,959.4 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 1,874.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл **95.6 хувийн биелэлттэй** байна.

Үүнээс гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих 75 төслийн зээлийн ашиглалтад 1,542.4 тэрбум төгрөг батлагдсанаас 1,530.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 99 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Харин тусламжийн 27 төслийн ашиглалтад 417.0 тэрбум төгрөг батлагдсанаас 344.2 тэрбум төгрөгийн ашиглалт гарч, гүйцэтгэл 83 хувьтай байна.

| ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ - 2025 |                  |                    |             |
|-----------------------------|------------------|--------------------|-------------|
| НИЙТ                        | ХЭЛЭЛЦЭЭРИЙН ДҮН | 2025 ОНД САНХҮҮЖИХ | ГҮЙЦЭТГЭЛ   |
| <b>102</b>                  | <b>21.1</b>      | <b>2.0</b>         | <b>95.6</b> |
| ТӨСӨЛ                       | ИХ НАЯД ТӨГРӨГ   | ИХ НАЯД ТӨГРӨГ     | ХУВЬ        |

Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хөгжлийн түнш тус бүрээр нь авч үзвэл Бүгд Найрамдах Энэтхэг Улсын санхүүжилт хамгийн өндөр буюу 23 хувийг эзэлж байгаа бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсын санхүүжилт 19 хувь, Азийн хөгжлийн банкны санхүүжилт 15 хувийг тус тус эзэлж байна.

| Хүснэгт 30. Гадаад зээл, тусламжийн гүйцэтгэл, хөгжлийн түншээр (тэрбум төгрөг) |       |            |           |          |      |
|---------------------------------------------------------------------------------|-------|------------|-----------|----------|------|
| Хөгжлийн түнш                                                                   | Төсөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Үлдэгдэл | Хувь |
| Австри Улс                                                                      | 2     | 25.7       | 25.7      | -        | 100% |
| Азийн Дэд Бүтэц Хөрөнгө Оруулалтын Банк                                         | 1     | 0.02       | 0.02      | -        | 100% |
| Япон Улс                                                                        | 1     | 15.8       | 15.8      | -        | 100% |
| Бүгд Найрамдах Франц Улс                                                        | 3     | 108.5      | 108.5     | -        | 100% |
| Европын Хөрөнгө Оруулалтын Банк                                                 | 2     | 15.8       | 15.7      | -        | 100% |
| Бүгд Найрамдах Хятад Ард Улс                                                    | 6     | 378.8      | 378.5     | 0.3      | 100% |
| Бүгд Найрамдах Энэтхэг Улс                                                      | 2     | 453.7      | 452.3     | 1.5      | 100% |
| Бүгд Найрамдах Солонгос Улс                                                     | 7     | 134.2      | 132.1     | 2.1      | 98%  |
| Дэлхийн Банк                                                                    | 12    | 121.9      | 116.5     | 5.4      | 96%  |
| Боловсролын Дэлхийн Түншлэл                                                     | 1     | 8.7        | 8.3       | 0.4      | 95%  |
| Азийн Хөгжлийн Банк                                                             | 45    | 291.4      | 268.2     | 23.3     | 92%  |
| АНУ-Мянганы Сорилтын Сан                                                        | 1     | 267.9      | 244.5     | 23.4     | 91%  |
| Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк                                           | 12    | 79.6       | 70.7      | 8.9      | 89%  |
| Польш Улс                                                                       | 2     | 10.4       | 8.3       | 2.1      | 79%  |
| Люксембургийн Их Гүнт Улс                                                       | 1     | 4.5        | 3.5       | 0.9      | 79%  |
| Кувейт Улс                                                                      | 1     | 2.8        | 1.8       | 0.9      | 66%  |

|                                    |            |                |                |             |              |
|------------------------------------|------------|----------------|----------------|-------------|--------------|
| Холбооны Бүгд Найрамдах Герман Улс | 3          | 39.6           | 24.5           | 15.1        | 62%          |
| <b>НИЙТ</b>                        | <b>102</b> | <b>1,959.4</b> | <b>1,874.9</b> | <b>84.6</b> | <b>95.7%</b> |

Нийт гадаад зээл, тусламжийн ашиглалт 2025 онд **96 хувийн гүйцэтгэлтэй**, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Цахим, хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Монгол Улсын Шадар сайд /Онцгой байдлын асуудал эрхэлсэн/, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Зам, тээврийн сайд нарын хэрэгжүүлж буй төслүүдийн зээл, тусламжийн ашиглалт 98-аас дээш хувийн гүйцэтгэлтэй байна.


| <b>Хүснэгт 31. Гадаад зээл, тусламжийн гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчаар (тэрбум төгрөг)</b> |            |                |                |             |              |
|------------------------------------------------------------------------------------------------------|------------|----------------|----------------|-------------|--------------|
| Төсвийн ерөнхийлөн захирагч                                                                          | Төсөл      | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | Үлдэгдэл    | Хувь         |
| Хууль зүй, дотоод хэргийн сайд                                                                       | 2          | 13.9           | 13.9           | -           | 100%         |
| Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд                                                                      | 1          | 446.9          | 446.1          | 0.8         | 99.8%        |
| Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд                                                        | 2          | 30.3           | 30.2           | 0.2         | 99.5%        |
| Монгол Улсын Шадар сайд /Онцгой байдлын асуудал эрхэлсэн/                                            | 3          | 45.7           | 45.4           | 0.3         | 99.4%        |
| Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд                                                        | 1          | 11.2           | 11.1           | 0.1         | 99.0%        |
| Зам, тээврийн сайд                                                                                   | 7          | 99.4           | 97.6           | 1.8         | 98.2%        |
| Эрчим хүчний сайд                                                                                    | 15         | 365.3          | 357.6          | 7.7         | 97.9%        |
| Боловсролын сайд                                                                                     | 7          | 62.7           | 61.4           | 1.4         | 97.8%        |
| Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд                                                     | 6          | 145.8          | 142.1          | 3.7         | 97.4%        |
| Эрүүл мэндийн сайд                                                                                   | 12         | 86.5           | 83.6           | 2.9         | 96.7%        |
| Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд                                                          | 4          | 11.7           | 11.1           | 0.6         | 95.0%        |
| Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд                                    | 1          | 2.2            | 2.1            | 0.1         | 94.4%        |
| Нийслэлийн Засаг дарга                                                                               | 21         | 261.3          | 244.7          | 16.6        | 93.7%        |
| Сангийн сайд                                                                                         | 9          | 306.0          | 278.7          | 27.3        | 91.1%        |
| Орхон аймгийн Засаг дарга                                                                            | 3          | 15.9           | 14.1           | 1.8         | 88.6%        |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд                                                          | 6          | 31.3           | 26.9           | 4.4         | 86.1%        |
| Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд                                                        | 2          | 23.50          | 8.40           | 15.1        | 35.7%        |
| <b>ЗЭЭЛ</b>                                                                                          | <b>75</b>  | <b>1,542.4</b> | <b>1,530.6</b> | <b>11.8</b> | <b>99.2%</b> |
| <b>ТУСЛАМЖ</b>                                                                                       | <b>27</b>  | <b>417.0</b>   | <b>344.2</b>   | <b>72.8</b> | <b>82.5%</b> |
| <b>НИЙТ</b>                                                                                          | <b>102</b> | <b>1,959.4</b> | <b>1,874.9</b> | <b>84.6</b> | <b>95.7%</b> |

## ДНБ-д эзлэх гадаад зээл, тусламж

Монгол Улсын Засгийн газар 2020-2025 онд хөгжлийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд 8,251.9 тэрбум төгрөгийн зээл, 1,695.9 тэрбум төгрөгийн тусламж, нийт 9,947.8 тэрбум төгрөгийн гадаад зээл, тусламжийг 19 хөгжлийн түнш, олон улсын байгууллагаас авч ашигласан.

Гадаад зээл, тусламжийн ашиглалт 2025 онд 1,874.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 25.2 хувиар буурсан бөгөөд энэ нь **ДНБ-ий 1.9 хувийг эзэлж байгаа** нь өмнөх оны үзүүлэлтээс 1.6 функтээр буурсан үзүүлэлт юм.

Зураг 25. Гадаад зээл, тусламжийн ашиглалт (их наяд төгрөг), ДНБ-д эзлэх хувь





## 2.3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

### Төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны гүйцэтгэл

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого болон “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, бүсүүдийн авто зам, эрчим хүч, дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор хөгжлийн бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлж, мөн бусад салбарт өмнөх онуудад эхлүүлсэн төслүүдийг дуусгаж, шинэ хөрөнгө оруулалтыг түр хойшлуулах зарчмыг 2025 онд баримталсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр **611 төсөл**, арга хэмжээний санхүүжилтэд **2,914.9 тэрбум төгрөг**, концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан **2 төсөл**, арга хэмжээний эргэн төлөлтөд **107.1 тэрбум төгрөг** тус тус батлагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 611 төсөл, арга хэмжээнээс шинээр хэрэгжүүлсэн 106 төсөл, арга хэмжээнд 707.3 тэрбум төгрөг, өмнөх онуудаас шилжин хэрэгжсэн. 505 төсөл, арга хэмжээнд 1,417.1 тэрбум төгрөгийн, концессын эргэн төлөлтөд 11,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож гүйцэтгэл 70.7%-ийн биелэлттэй гарлаа.

Мөн эдгээр төслүүдийг санхүүжүүлснээр 850 орчим аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, 110.0 мянган ажлын байрыг хэвээр хадгалж, 2,135.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр эдийн засгийг дэмжлээ.

| ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ – 2025 |                |                       |             |
|---------------------------------|----------------|-----------------------|-------------|
| НИЙТ                            | ТӨСӨВТ ӨРТӨГ   | 2025 ОНД<br>САНХҮҮЖИХ | ГҮЙЦЭТГЭЛ   |
| <b>613</b>                      | <b>9.0</b>     | <b>3.0</b>            | <b>70.7</b> |
| ТӨСӨЛ                           | ИХ НАЯД ТӨГРӨГ | ИХ НАЯД ТӨГРӨГ        | ХУВЬ        |

Улсын хэмжээнд нийт 320 барилга, байгууламж ашиглалтад орсон ба үүнээс 218 нь дэд бүтцийн салбарт, 120 нь нийгмийн салбарт багтаж байна.

Их засварын 77 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэл 94.5 хувьтай гарсан бол тоног, төхөөрөмжийн шинэчлэлтэд чиглэсэн 442 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж гүйцэтгэл 85.8 хувьтай гарлаа

## 1. ДНБ БА ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


Төсвийн хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх зохистой хэмжээ олон улсын жишиг, судалгаанаас үзэхэд дараах нийтлэг чиг хандлага байна:



**Хөгжиж буй орнуудын хувьд:** Төсвийн хөрөнгө оруулалт ДНБ-ий 4-8 орчим хувь байх нь зохистой гэж үздэг. Хэт бага байвал дэд бүтэц, нийгмийн салбарын хөгжил удааширч, хэт өндөр байвал төсөвт дарамт учруулж болзошгүй.


**Хөгжсөн орнуудын хувьд:** ДНБ-ий 2-4 орчим хувь байхад хангалттай гэж үздэг. Эдгээр оронд дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн тул хөрөнгө оруулалтын хэрэгцээ харьцангуй бага байдаг.

**Зураг 26. УТХО-ын нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь, ДНБ-д эзлэх хувь**



Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зардлын дунджаар 13 хувь, ДНБ-ий дунджаар 4 хувь байгаа нь хөгжиж буй орны хувьд хангалттай үзүүлэлт боловч гол асуудал нь үр ашгийн үзүүлэлт чухал хэвээр байна.

## 2. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, 2020-2025 ОН



### Хүснэгт 32. Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчаар

| ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ                                       | ТӨСӨЛ | БАТЛАГДСАН | ОЛГОСОН | ҮЛДЭГДЭЛ | ХУВЬ  |
|-------------------------------------------------------------------|-------|------------|---------|----------|-------|
| Монгол Улсын Ерөнхий сайд                                         | 1     | 1.4        | 1.4     | -        | 100%  |
| Шүүхийн сахилгын хорооны дарга                                    | 1     | 0.3        | 0.3     | -        | 100%  |
| Хүний эрхийн үндэсний комиссын дарга                              | 1     | 2.3        | 2.3     | -        | 100%  |
| Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд                                   | 1     | 0.8        | 0.8     | -        | 100%  |
| Санхүүгийн зохицуулах хорооны дарга                               | 1     | 0.2        | 0.2     | -        | 100%  |
| Улсын Ерөнхий прокурор                                            | 5     | 29.8       | 29.8    | -        | 100%  |
| Монгол Улсын Ерөнхийлөгч                                          | 2     | 0.7        | 0.7     | -        | 100%  |
| Үндэсний статистикийн хорооны дарга                               | 1     | 1.8        | 1.8     | 0.0      | 99.6% |
| Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч                                  | 3     | 4.1        | 4.1     | 0.0      | 99.2% |
| Авлигатай тэмцэх газрын дарга                                     | 2     | 2.3        | 2.3     | 0.0      | 99.1% |
| Батлан хамгаалахын сайд                                           | 4     | 65.8       | 64.6    | 1.2      | 98.2% |
| Монгол Улсын Шадар сайд                                           | 7     | 41.6       | 40.7    | 0.9      | 97.9% |
| Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга       | 17    | 23.2       | 21.7    | 1.5      | 93.7% |
| Хууль зүй, дотоод хэргийн сайд                                    | 18    | 104.7      | 94.6    | 10.1     | 90.3% |
| Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд                     | 13    | 69.5       | 61.0    | 8.5      | 87.8% |
| Гадаад харилцааны сайд                                            | 2     | 9.6        | 8.2     | 1.4      | 85.5% |
| Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга                                   | 7     | 52.7       | 44.4    | 8.4      | 84.1% |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд                       | 17    | 56.3       | 45.5    | 10.8     | 80.9% |
| Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд                       | 24    | 48.7       | 38.5    | 10.3     | 78.9% |
| Боловсролын сайд                                                  | 184   | 446.4      | 341.6   | 104.8    | 76.5% |
| Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд                     | 48    | 125.6      | 95.3    | 30.3     | 75.9% |
| Зам, тээврийн сайд                                                | 95    | 918.1      | 668.1   | 250.0    | 72.8% |
| Эрүүл мэндийн сайд                                                | 38    | 145.9      | 97.9    | 48.0     | 67.1% |
| Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд | 5     | 39.4       | 25.6    | 13.8     | 65.0% |
| Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд                  | 56    | 334.8      | 215.7   | 119.0    | 64.4% |

|                                               |            |                |                |              |              |
|-----------------------------------------------|------------|----------------|----------------|--------------|--------------|
| Монгол Улсын Их Хурлын дарга                  | 1          | 8.6            | 5.3            | 3.3          | 61.6%        |
| Эрчим хүчний сайд                             | 42         | 229.4          | 132.9          | 96.6         | 57.9%        |
| Сангийн сайд                                  | 10         | 127.7          | 67.4           | 60.4         | 52.7%        |
| Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд | 5          | 23.4           | 12.0           | 11.4         | 51.3%        |
| <b>УЛСЫН ТӨСВИЙН ДҮН</b>                      | <b>611</b> | <b>2,914.9</b> | <b>2,124.4</b> | <b>790.5</b> | <b>72.9%</b> |
| Концесс                                       | 2          | 107.1          | 11.0           | 96.1         | 10.3%        |
| <b>НИЙТ</b>                                   | <b>613</b> | <b>3,022.0</b> | <b>2,135.4</b> | <b>886.6</b> | <b>70.7%</b> |

### 3. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ /БҮСЭЭР/

#### Хүснэгт 33. Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, бүсээр

| ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ    | ТӨСӨЛ      | БАТЛАГДСАН     | ОЛГОСОН        | ҮЛДЭГДЭЛ     | ХУВЬ         |
|--------------------------|------------|----------------|----------------|--------------|--------------|
| Барилга байгууламж       | 527        | 2,426.5        | 1,702.2        | 820.4        | 70.2%        |
| Их засвар                | 23         | 119.4          | 112.8          | 6.6          | 94.5%        |
| Тоног төхөөрөмж          | 54         | 347.6          | 297.8          | 49.7         | 85.7%        |
| ТЭЗҮ                     | 7          | 21.5           | 11.5           | 10           | 53.5%        |
| <b>УЛСЫН ТӨСВИЙН ДҮН</b> | <b>611</b> | <b>2,914.9</b> | <b>2,124.4</b> | <b>790.5</b> | <b>72.9%</b> |
| Концесс                  | 2          | 107.1          | 11.0           | 96.1         | 10.3%        |
| <b>НИЙТ</b>              | <b>613</b> | <b>3,022.0</b> | <b>2,135.4</b> | <b>886.6</b> | <b>70.7%</b> |

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” батлагдсан бөгөөд тухайн бүс нутгийн онцлогт тулгуурласан хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Энэ хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлсэн төслүүдийг бүс нутгаар нь харвал Говийн бүсийн гүйцэтгэл хамгийн өндөр буюу 86 хувь, Төвийн бүсийн гүйцэтгэл хамгийн бага буюу 62 хувьтай тус тус гарсан бөгөөд улсын хэмжээнд гүйцэтгэл дунджаар 74 хувьтай байна.

### 4. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ХЭМНЭЛТ

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зорилго нь төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавих бөгөөд ингэснээр төсвийн сахилга бат, хариуцлагыг

нэмэгдүүлэх, үр дүнгүй, гүйцэтгэлгүй, удааширсан төсвийн зардлыг хязгаарлахад чиглэсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтад “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;” гэж, 13.1.2 дахь заалтад “энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох;” гэж тус тус заасны дагуу 2025 оны 05 дугаар сарын 31-ний дотор худалдан авах ажиллагааг бүрэн дуусгаж, гэрээ байгуулаагүй төслүүдийн санхүүжилтийг хэмнэлтэд тооцох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор “Төсвийн хэмнэлтэд тооцох тухай” асуудлыг Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 02 дугаар тогтоолоор баталсан. Уг тогтоолын хүрээнд нийт 535.9 тэрбум төгрөгийг төсвийн хэмнэлтэд тооцсон.

Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний үр ашгийг сайжруулах, төсвийн хөрөнгийг оновчтой зөв хуваарилах, хэмнэлтийн хуульд нийцүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Тухайлбал:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 2025 оны жилийн эцсийн байдлаар 2,135.4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, гүйцэтгэл 70.7%-тай гарсан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” гэж заасны дагуу хяналт тавьж батлагдсан санхүүжилтээс тендерийн хэмнэлт, гэрээ цуцалсантай холбогдуулан 49.7 тэрбум төгрөг, гүйцэтгэлийн хэмнэлт болох 13.7 тэрбум төгрөгийг тус тус хэмнэгдэж, нийт 63.4 тэрбум төгрөгийг төсвийн хөрөнгө оруулалтаас хэмнэсэн байна.

2. Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтын санал боловсруулахад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан дараах заалтуудыг зарчим болгон баримталж, төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөн ажилласан. Үүнд:

2.1 Хуулийн 13.1.3-т “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” гэсэн заалтын хүрээнд нийтдээ 58.7 тэрбум төгрөгийн тендерийн хэмнэлтийг хасаж төсвийн төсөлд тусгасан.

2.2 Хуулийн 13.4-т “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”

13.4.1-д “орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт”

13.4.2-т “орон нутгийн хог хаягдлын асуудал”

13.4.3-т “орон нутгийн авто замын засвар хийх”

13.4.4-т “багийн төв, хорооны засаг захиргааны зориулалттай барилга барих, тохижуулах, засварлах, тоног төхөөрөмж худалдан авах”

13.4.5-д “айл, өрхийн ариун цэврийн байгууламж, гудамжны тохижилт”  
13.4.6-д “нийтийн эзэмшлийн байр, орон сууцны засвар, шинэчлэл”

### **Боловсролын салбарын төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны гүйцэтгэл:**

Боловсролын салбарт 2025 онд төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 184 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, 341.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, нийт 93 сургууль, цэцэрлэг, дотуур байр ашиглалтад орсон бол гадаад зээл, тусламжаар 62.3 тэрбум төгрөгийн ашиглалт гарсан байна.

Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсанаар ерөнхий боловсролын сургуулийн стандартыг сайжруулах, 3 ээлжээр хичээллэж байгаа сургуулиудын ачааллыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалтын бодлогыг чиглүүлээ.



### ***Ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх төсөл***

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын хүрээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын нийгмийн хариуцлагын хүрээнд үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 2025 онд 124.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 209 цэцэрлэг, 318 сургууль, 238 дотуур байрын ариун цэврийн байгууламжтай болсон байна.

### ***Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд чиглэсэн хөрөнгө оруулалт***

Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сурч, хөгжих орчныг бүрдүүлэх зорилгоор улсын хэмжээнд нийт 8.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 3 ясли, цэцэрлэг, сувиллын барилгын ажлыг хэрэгжүүлж, үүнээс Өвөрхангай аймагт 1 цэцэрлэг, Сэлэнгэ аймагт 1 сувиллын барилга ашиглалтад орлоо.

### ***Боловсролын салбарын тоног төхөөрөмжийн санхүүжилт:***

2025 онд улсын хэмжээнд 55 тоног, төхөөрөмжийн төсөл хэрэгжиж, 28.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олголоо. Үүнээс 2025 онд шинээр хэрэгжиж эхэлсэн 29 төсөл, арга хэмжээний хүрээнд 16.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

### **Зам, тээврийн салбарын төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны гүйцэтгэл:**

Шинэ сэргэлтийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн зорилтын хүрээнд хилийн боомтыг холбох, аялал жуулчлалын чиглэлийн авто замын сүлжээг хөгжүүлэх, авто замын засвар, арчлалтын чанар, хугацааг сайжруулах чиглэлээр төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөж, 2025 онд зам, тээврийн салбарт нийт 1,017.4 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан.

### **Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт**

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1.2.3.3.-т Хилийн боомт, аялал жуулчлалын бүс, аймаг, сумдыг холбосон “Шинэ сэргэлтийн Таван тойрог” авто замын төслийг үе шаттай хэрэгжүүлнэ гэсэн зорилтын хүрээнд 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,212.6 км урт бүхий нийт 26 замын бүтээн байгуулалтын ажил тусгагдсан. Тухайлбал, аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд Өндөрхаан-Норовлин чиглэлийн 130 км хатуу хучилттай авто замын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, аймаг хооронд холбох Ховд-Улаангом чиглэлийн 163 км авто зам, Улиастай-Алтай чиглэлийн 100 км авто замын ажлыг Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлж байна.

Мөн стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон авто замын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна:

- Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн авто зам, 124.5км /47%/
- Чойбалсан хотоос Ульхан боомт чиглэлийн авто зам, 50км /62%/
- Өлгий - Улаанхус сум - Алтай таван богд уул чиглэлийн авто зам, 23.13км /43%/

### **2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮН**

**+425км**

урт бүхий 33 авто зам  
ашиглалтад орлоо

**+186 у/м**


урт бүхий 2 гүүр ашиглалтад  
орлоо

### **Эрчим хүчний салбарын төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны гүйцэтгэл:**

Эрчим хүчний хангамжийг тогтвортой, найдвартай, хүртээмжтэй болгох, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, дамжуулалт, хэрэглээний бүх үе шатанд шинэ технологи, инновацыг нэвтрүүлж үр ашгийг дээшлүүлэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж технологи, мэдлэгийн шилжилтийг дэмжих бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэн ажилласан.

Дээрх бодлогын зорилтуудын хүрээнд 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 229.4 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 132.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 57.9 хувь, гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 594.6 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 490.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 82.5 хувьтай гарсан байна.

### Зураг 27. Эрчим хүчний салбарын төсвийн хөрөнгө оруулалт 2025



Баруун бүсийн эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах зорилготой Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийг БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төсөл нь сэргээгдэх эх үүсвэрийг нэмэгдүүлэх, импортын эрчим хүчний хамаарлыг бууруулах стратегийн ач холбогдолтой. Мөн Чойр–Сайншандын 220 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын төслийг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр, сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийг Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр тус тус хэрэгжүүлж байна.

**ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД:**

## НЭГ. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦАХИМ ШИНЭЧЛЭЛ

Сангийн яам Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем нь 2025 оны сүүлийн байдлаар 8 дэд системээр дамжуулан, бусад төрийн 14 байгууллагын 24 системтэй холбогдож, өгөгдөл солилцон ажиллаж байна. 2025 онд [www.publicinvestment.gov.mn](http://www.publicinvestment.gov.mn) вэб сайтад нийт 14,050 хандалт, хөрөнгө оруулалтын үндсэн системд 7,401 хэрэглэгчээс 213,087 хандалт хийгдсэн бөгөөд гар утасны аппликейшн 11,711 удаа татагдсан байна.





## ТХОУЦС-д 2025 онд дараах шинэчлэлүүд хийгдлээ. Үүнд:

|                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>2026 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн 1712 төсөл дээр иргэдийн саналыг анх удаа авахад давтагдсан тоогоор 106 мянга гаруй санал ирлээ.</p>                                    | <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдийн товчоог веб сайтад ил тод, нээлттэй болголоо.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| <p>Монгол улсын Засгийн Газрын гадаад зээлээр хэрэгжүүлж буй төслүүдийн төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдийн төлөвлөгөөг хийх, ажилтны цалин тогтоох, гэрээ байгуулах, үнэлгээ хийх, тайлан биелэлт оруулах зэрэг үйл ажиллагааг цахим болголоо.</p> | <p>Төсвийн хөрөнгө оруулалтын их өгөгдөл, хиймэл оюун ухааны дэд системийг <a href="http://www.map.publicinvestment.gov.mn/">www.map.publicinvestment.gov.mn/</a> ашиглалтад орууллаа. Цаашид, их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан хөрөнгө оруулалтын бүх эх үүсвэрийг нэгтгэж, хөрөнгө оруулалтын их өгөгдөлд суурилсан мэдээллийн сан үүсгэж, уялдаа холбоотой, үр ашигтай хөрөнгө оруулалтын нэгдсэн платформ хөгжүүлэх зорилго тавин ажиллаж байна.</p> |

## ХОЁР: ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг цахим системээр хэрэгжүүлэх, нийгмийн үр өгөөж, эдийн засгийн үр ашиг, ач холбогдлын шинжилгээг хэрхэн хийх талаар 11 дэх удаагийн “Чадавх бэхжүүлэх” сургалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, цахим системийн үйл ажиллагаатай холбоотой заавар, зөвлөгөөг төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцогч талуудад өглөө.



Мөн ТХОУЦС-д төсөл, арга хэмжээг төлөвлөхтэй холбоотой цахим сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор сум/дүүргийн 520 гаруй мэргэжилтнүүдийг хамрууллаа.

**“Давхардсан тоогоор 1,400 гаруй албан хаагчийг сургалт болон хэлэлцүүлэгт хамруулж, нийт 8,100 гаруй хэрэглэгчдэд тусламж, заавар зөвлөгөө өглөө.**

Гадаад зээл, тусламжаар төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааг ТХОУЦС-д шилжүүлсэнтэй холбоотойгоор 2 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, 170 гаруй мэргэжилтнийг хамрууллаа.

### **ГУРАВ. ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТӨСЛҮҮДИЙГ НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЖ БАЙНА.**

Гадаад зээл, тусламжийн төслүүдийн бүтэц орон тоонд шинэчлэл хийж Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид (НТХН) шилжүүллээ.

НТХН-д шилжсэнээр төслийн ажилчид, хүний нөөцийн тогтвортой байдал нэмэгдэх боломж бүрдэхийн зэрэгцээ түрээсийн зардал болон бусад урсгал зардал багасаж жилд дунджаар 2.2 тэрбум төгрөгийн хэмнэлт гарахаар байна.



### **ДӨРӨВ. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛЖ БАЙНА.**


Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл төлөвлөхөөс эхлээд хэрэгжүүлэх, ашиглалтад оруулах, өмчид өгөх бүхий л үйл ажиллагааг сайжруулах, үр ашигтай болгох, гадаад зээл, тусламж болон бусад эх үүсвэрийн зохицуулалтыг оновчтой болгох, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, ил тод байдал, тайлагналтыг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийг олон нийтэд танилцуулах, санал авахтай холбоотой 5 хэлэлцүүлгийг амжилттай зохион байгууллаа.

| Зорилго                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Үйлчлэх хүрээ                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Үр дүн                                                                                                                                                                                                               |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>Хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд</b> нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, хөрөнгийн удирдлага, ашиглалтыг ил тод, үр ашигтай хэрэгжүүлэхтэй холбогдуулан <b>төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын эрх зүйн нэгдмэл орчныг бүрдүүлэхэд оршино.</b></p> | <ul style="list-style-type: none"> <li>Улсын төсөв</li> <li>Гадаадын зээл</li> <li>Орон нутгийн төсөв</li> <li>Орон нутгийн хөгжлийн сан</li> </ul> <p><b>Зохицуулах харилцаа:</b> Төслийг эрэлт хэрэгцээнд үндэслэн үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах, хөрөнгийн удирдлага, ашиглалтын бүрэн үйл ажиллагаа</p> <p><b>Тусгайлан зохицуулах:</b> худалдан авах ажиллагааг холбогдох хуулиар, төрийн нууцтай холбоотой асуудлыг тусгайлан хуулиар зохицуулна</p> | <ul style="list-style-type: none"> <li>✓ <b>8</b> бүлэг</li> <li>✓ <b>52</b> зүйл</li> <li>✓ <b>215</b> хэсэг</li> <li>✓ <b>219</b> заалт</li> <li>✓ <b>2</b> хүснэгт</li> <li>✓ <b>5</b> заалтын тайлбар</li> </ul> |

## ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2025 ОНЫ ҮР ДҮН:

Төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд 2025 онд нийт 4.0 их наяд төгрөгийн санхүүжилтийг эдийн засагт нийлүүлсэн нь бодит салбарын идэвхжилтийг дэмжихэд чухал нөлөө үзүүлсэн байна. Үүний санхүүжилтийн үр дүнд барилга, дэд бүтэц, эрчим хүч, үйлчилгээ зэрэг олон салбарт хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн дам нөлөөгөөр нийт 110.1 мянган ажлын байрыг хадгалсан.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 613 төсөл, арга хэмжээний 1392 багц төсөлд 3.0 их наяд төгрөг батлагдаж 2.1 их наяд төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Уг санхүүжилтийн хүрээнд нийтдээ 1.9 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 807 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, түүнээс 2.2 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 451 барилга, байгууламж ашиглалтад орсон.

| <b>Хүснэгт 34. Улсын төсвийн санхүүжилтээр ашиглалтад орсон барилга, байгууламж</b> |              |                                  |
|-------------------------------------------------------------------------------------|--------------|----------------------------------|
| <b>Хөрөнгө оруулалтын төрөл</b>                                                     | <b>Төсөл</b> | <b>Төсөвт өртөг (сая төгрөг)</b> |
| Дотуур байр                                                                         | 12           | 63.9                             |
| Зам, гүүр                                                                           | 67           | 646.7                            |
| Инженерийн дэд бүтэц                                                                | 44           | 234.4                            |
| Концесс                                                                             | 1            | 63.2                             |
| Соёлын төв, музей, театр                                                            | 14           | 59.4                             |
| Спорт заал, цогцолбор, ордон                                                        | 13           | 141.8                            |
| Сургууль                                                                            | 39           | 248.3                            |
| Цахилгаан, дулаан хангамж                                                           | 46           | 190.9                            |
| Цэцэрлэг                                                                            | 42           | 126.8                            |
| Эмнэлэг                                                                             | 23           | 2,167.8                          |
| Бусад                                                                               | 150          | 392.3                            |
| <b>Нийт</b>                                                                         | <b>451</b>   | <b>2,167.0</b>                   |

2025 онд олон жил удааширсан томоохон төслүүд амжилттай дуусаж, бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийг найдвартай дулаан, цахилгаан, ундны усаар хангах зэрэг чухал ач холбогдолтой бүтээн байгуулалтууд ашиглалтад орлоо.

Гадаад зээл, тусламжийн (ГЗТ) санхүүжилтийн үр дүнд 247.5 км авто зам, холбогдох барилга байгууламжийг ашиглалтад оруулснаар бүс нутгийн холболт сайжирч, тээврийн зардал, хугацаа буурах нөхцөл бүрдсэн байна. Цахилгаан, дулааны шугам сүлжээний ажлууд хэрэгжсэнээр эрчим хүчний найдвартай, тасралтгүй хангамжийг нэмэгдүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээний тасалдлыг бууруулахад дэмжлэг үзүүлж байна.

Түүнчлэн, шинээр ашиглалтад орсон барилга, байгууламжууд болон эрүүл мэнд, боловсролын салбарт нийлүүлсэн тоног төхөөрөмж нь үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, хүний хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулж байна.

| <b>Хүснэгт 35. Гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр ашиглалтад орсон барилга, байгууламж</b> |            |                      |
|-----------------------------------------------------------------------------------------------|------------|----------------------|
| <b>Хөрөнгө оруулалтын төрөл</b>                                                               | <b>Тоо</b> | <b>Хөрөнгийн дүн</b> |
| Зам, гүүр                                                                                     | 6          | 490.5                |
| Дулаан хангамж                                                                                | 14         | 70.8                 |
| Шилэн кабел, мэдээллийн систем                                                                | 6          | 4.3                  |
| Эмнэлэг                                                                                       | 1          | 17.2                 |
| Орон сууц, барилга                                                                            | 6          | 63.7                 |

|                                 |           |              |
|---------------------------------|-----------|--------------|
| <b>Инженерийн шугам, сүлжээ</b> | <b>1</b>  | <b>1.8</b>   |
| <b>Усалгааны систем</b>         | <b>5</b>  | <b>30.8</b>  |
| <b>Нийт</b>                     | <b>39</b> | <b>679.1</b> |

Азийн хөгжлийн банкны санхүүжилтийн хөрөнгөөр Эрүүл мэндийн яаман дээр хэрэгжүүлж буй “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл”-ийн 17.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг амжилттай дуусган, Улсын комисс хүлээн авч байнгын ашиглалтад оруулаад байна. Мөн Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпораци хооронд байгуулсан II Компакт гэрээ буюу Усны Компактын гурван үндсэн төслийн нэг “Хаягдал ус дахин боловсруулах төсөл”-ийн хүрээнд шинэ Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд бүтээн байгуулсан Монголын анхны томоохон Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийг нээн үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна.

Мөн олон жил удааширсан томоохон төслүүдийг үе шаттайгаар дуусган ашиглалтад оруулснаар бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтэд ахиц гарч, орон нутгийн дэд бүтцийн хүртээмж нэмэгдэн, иргэдийг найдвартай дулаан, цахилгаан, ундны усаар хангах чиглэлд бодит үр дүн гарсан байна. Түүнчлэн одоо хэрэгжүүлж байгаа мега төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулахаар ажиллаж байна.

## 2.4. ЗАСГИЙН ГАЗРЫН НӨӨЦ САН

Монгол Улсын Засгийн газрын нөөц сангийн 2025 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарьт нийцүүлэн, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавин, хэрэгжилтийг хангаж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.2-т “Засгийн газрын нөөц сан нь энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын төсвийн багцад Засгийн газрын нөөц санг 100 хувь төсвөөс санхүүжихээр тусгасан.

Засгийн газрын нөөц сан 2025 онд 148.2 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 2025 онд Засгийн газрын нөөц сангаас Засгийн газрын 45 тогтоолоор 106.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон 71.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

### Хүснэгт 36. ЗГ-ын нөөц сангийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/

| Үзүүлэлт                                         | Дүн   |
|--------------------------------------------------|-------|
| 2025 оны ЗГ-ын нөөц сангийн төлөвлөгөө           | 148.2 |
| Засгийн газрын тогтоолоор нийт санхүүжүүлсэн дүн | 106.1 |
| Үүнээс: 2020, 2024 оны тогтоолын дүн             | 38.0  |
| 2025 оны тогтоолын дүн                           | 68.1  |

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.5-д заасан арга хэмжээний хүрээнд 2025 онд Засгийн газрын нөөц сангаас:

- Гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан осол гарсан үед хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах, эрсдэлийг бууруулах зардалд 38.4 тэрбум төгрөг;

- Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдснөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх зардалд 0.8 тэрбум төгрөг

- Олон улсын шүүх, арбитраг хариуцагчаар татагдсан буюу тэдгээрээс гарсан шийдвэрийг биелүүлэхэд 20.5 тэрбум төгрөг;

- Төсвийн жилийн дундуур баталсан Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд 46.4 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### 3. ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН

Төсвийн тухай хуулийн 8.9.1, 54.4, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.9, 24 дүгээр зүйлд заасны дагуу Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд гаргалаа.

Баялгийн сан нь Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сангаас бүрдэнэ. Тус санд 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлогын хэмжээг 1,956.2 тэрбум төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 2,313.6 тэрбум төгрөг төвлөрч 118.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант оны төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 37. Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Үзүүлэлт                                                 | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | Зөрүү        | Хувь         |
|----------------------------------------------------------|----------------|----------------|--------------|--------------|
| <b>Татаас, санхүүжилтийн орлого</b>                      | <b>1,956.2</b> | <b>2,313.6</b> | <b>357.4</b> | <b>118.3</b> |
| Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр                    | 1,256.0        | 1,566.3        | 310.4        | 124.7        |
| Хөрөнгө оруулалтын орлого                                | 138.1          | 144.3          | 6.2          | 104.5        |
| Хувьцааны ноогдол ашиг                                   | 507.1          | 507.1          |              | 100.0        |
| Хүүгийн орлого                                           | 55.0           | 95.9           | 40.8         | 174.4        |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>            | <b>1,956.2</b> | <b>2,313.6</b> | <b>357.4</b> | <b>118.3</b> |
| <b>НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                 |                |                |              |              |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  |                | <b>3,979.4</b> |              |              |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b> |                | <b>6,293.0</b> |              |              |

**Ирээдүйн өв сан.** Ирээдүйн өв санд 2025 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 1,566.3 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын орлогоор 144.3 тэрбум төгрөг төвлөрсөн байна.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлд “Ирээдүйн өв сангийн хөрөнгийг 2030 он хүртэл санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөрөнгийн найдвартай, хөрвөх чадвартай байх нөхцөлийг зэрэг хангасны үндсэн дээр эрсдэл-өгөөжийн зохистой түвшинг баримтлан удирдах бөгөөд шаардлагатай тохиолдолд гэрээний үндсэн дээр Монголбанкаар дамжуулан хэрэгжүүлж болно” гэж заасан.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 7.1.1, 8.1.3-т заасны дагуу Үндэсний баялагийн сангийн хөрөнгийн удирдлагын бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж “Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагын бодлого батлах тухай” Засгийн газрын 72 дугаар тогтоол батлагдсан.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.1.1, 2.1-д заасны дагуу “Ирээдүйн өв сангийн хөрөнгөөс Төв банкад гадаад валютаар хадгаламж байршуулах гэрээ”-г 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Монголбанктай байгуулснаар , 2025 онд Монголбанктай 9 удаагийн хэлцэл байгуулан хадгаламж байршуулан 144.3 тэрбум төгрөгийн орлого оруулсан байна.

**Хуримтлалын сан.** Хуримтлалын санд 2025 онд 507.1 тэрбум төгрөгийн хувьцааны ноогдол ашиг, 95.8 тэрбум төгрөгийн хүүгийн орлого орсон байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.1.2, 10.3 дахь заалт, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 17 дугаар зүйлийн 4 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 228 дугаар тогтоолыг тус тус үндэслэн, Засгийн газрын 2025 оны 179 дүгээр тогтоолд Хуримтлалын санд төвлөрүүлсэн эх үүсвэрийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг санхүүжүүлэх, хуульд заасны дагуу арвижуулах зорилгоор нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, нөгөө талаас Монголбанк харилцан тохиролцож 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 98/A/132/2025/195/0525/183 дугаартай гэрээг байгуулж 95.8 тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг бүртгэсэн байна.

#### 4. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

Төсвийн тухай хуулийн 8.9.1, 54.4, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.9, 24 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргасан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос хуваарилалт хийсэн ба аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 119.0 тэрбум, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 443.5 тэрбум төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэв.

**Хүснэгт 38. Тогтворжуулалтын сангийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Үзүүлэлт                                      | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл    | Зөрүү        | Хувь         |
|-----------------------------------------------|--------------|--------------|--------------|--------------|
| <b>Татаас, санхүүжилтийн орлого</b>           | <b>429.1</b> | <b>562.5</b> | <b>133.4</b> | <b>131.0</b> |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар         | 81.2         | 119.0        | 37.8         | 146.6        |
| Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр         | 347.9        | 443.5        | 95.6         | 127.5        |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b> | <b>429.1</b> | <b>562.5</b> | <b>133.4</b> | <b>131.0</b> |
| Улсын төсвийн шилжүүлэг                       |              |              |              |              |
| <b>НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>      |              |              |              |              |

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор төсөв тусгагдаагүй тул тус сангаас зардал гараагүй байна.



## 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогод 2025 онд эрүүл мэндийн даатгалын хураамжийн шимтгэлийн орлогоор 2,464.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2,299.5 тэрбум төгрөг төвлөрч, 93.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнд: Нийгмийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн даатгалын санд 977.2 тэрбум төгрөг, Төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 352.2 тэрбум төгрөг, Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 921.6 тэрбум төгрөг, Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл 44.1 тэрбум төгрөг, торгууль, төлбөрийн орлого 4.4 тэрбум төгрөгийн орлого тус тус төвлөрсөн байна.

### Хүснэгт 39. ЭМДС-ийн төсөв /тэрбум төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ                                   | 2025 он        |                |              |               |
|--------------------------------------------|----------------|----------------|--------------|---------------|
|                                            | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | Хувь         | Зөрүү         |
| <b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>       | <b>2,464.3</b> | <b>2,299.5</b> | <b>93.3</b>  | <b>-164.8</b> |
| Нийгмийн даатгалын орлого                  | 2,464.3        | 2,299.5        | 93.3         | -164.8        |
| ЭМД-ын хураамжийн шимтгэл                  | 2,464.3        | 2,299.5        | 93.3         | -164.8        |
| <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>2,164.9</b> | <b>2,238.2</b> | <b>103.4</b> | <b>73.4</b>   |
| НИЙТ ЗАРЛАГА                               | 2,242.5        | 2,241.6        | 100.0        | -0.9          |
| УРСГАЛ ЗАРДАЛ                              | 2,242.5        | 2,241.6        | 100.0        | -0.9          |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ            | 13.9           | 13.2           | 94.1         | -0.9          |
| ТАТААС                                     | 171.1          | 171.1          | 100.0        | 0.0           |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                           | 2,057.4        | 2,057.4        | 100.0        | 0.0           |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | -77.6          | -3.4           | 4.4          | -74.2         |
| Эргэж төлөгдөх зээл                        | -77.6          | -3.4           | 4.4          | -74.2         |
| <b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>          | <b>299.4</b>   | <b>61.3</b>    |              |               |

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 2,242.4 тэрбум төгрөгөөр баталсан. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2,241.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд 1,489.7 тэрбум төгрөгийг, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардалд 536.7 тэрбум төгрөгийг, урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээнд 30.9 тэрбум төгрөгийг, эмийн үнийн хөнгөлөлтөд 171.1 тэрбум төгрөгийг тус тус Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон байна.

## 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Нийгмийн даатгалын сангийн орлогод 2025 онд 6,908.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс 6,684.4 тэрбум төгрөг төвлөрч, 96.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нийгмийн даатгалын сангийн орлогын хувьд нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн төлбөрт 5,231.9 тэрбум төгрөг төвлөрч, 95.9 хувийн биелэлттэй, улсын төсвөөс олгох татаас 1,452.5 тэрбум төгрөгт хүрч, 100.0 хувийн биелэлттэй байна.

### Хүснэгт 40. НДС-ийн төсөв /тэрбум төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ                                          | 2025 он         |                |               |                |
|---------------------------------------------------|-----------------|----------------|---------------|----------------|
|                                                   | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл      | Хувь          | Зөрүү          |
| <b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>              | <b>6,908.1</b>  | <b>6,684.4</b> | <b>96.8%</b>  | <b>-223.6</b>  |
| Татварын орлого                                   | 5,455.6         | 5,231.9        | 95.9%         | -223.6         |
| Нийгмийн даатгалын орлого                         | 5,455.6         | 5,231.9        | 95.9%         | -223.6         |
| Татварын бус орлого                               | 1,452.5         | 1,452.5        | 100.0%        | 0.0            |
| Хандив тусламж /дотоод/                           | 1,452.5         | 1,452.5        | 100.0%        | 0.0            |
| <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>          | <b>5,802.2</b>  | <b>5,846.9</b> | <b>100.8%</b> | <b>44.69</b>   |
| НИЙТ ЗАРЛАГА                                      | 5,869.5         | 5,848.5        | 99.6%         | -20.94         |
| УРСГАЛ ЗАРДАЛ                                     | 5,869.5         | 5,848.5        | 99.6%         | -20.94         |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                   | 1.4             | 0.9            | 66.5%         | -0.46          |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                  | 5,868.1         | 5,847.6        | 99.7%         | -20.47         |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ        | -67.2           | -1.6           | 2.4%          | 65.63          |
| <b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>                 | <b>1,105.9</b>  | <b>837.5</b>   | <b>75.7%</b>  | <b>-268.33</b> |
| <b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>           | <b>-1,105.9</b> | <b>-837.5</b>  | <b>75.7%</b>  | <b>268.33</b>  |
| Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | -1,105.9        | -837.5         | 75.7%         | 268.33         |

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2025 онд 5,846.9 тэрбум төгрөгт хүрч, нийт төлөвлөгөөний 100.8 хувьтай тэнцэж байна. Нийгмийн даатгалын сан нь 2025 онд 837.5 тэрбум төгрөгийн ашигтай тайлагнагдаж байна.

## 7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн орлогын 77.9 хувь татварын орлогоос, 22.1 хувь татварын бус орлогоос бүрдсэн байна. Татварын орлогын 50.0 хувь буюу 2,987.5 тэрбум төгрөг хувь хүний орлогын албан татвараар төвлөрсөн байна. Тайлант онд ХХОАТ-ын буцаалтаар иргэдэд 92.1 тэрбум төгрөгийг олгосон байна. Татварын бус орлогын 58.4 хувь буюу 989.3 тэрбум төгрөгийг нийтлэг татварын бус орлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг 24.3 хувь буюу 411.7 тэрбум төгрөг, улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг 16.1 хувь буюу 273.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

**Хүснэгт 41. Орон нутгийн төсөв /тэрбум төгрөг/**

| ҮЗҮҮЛЭЛТ                                           | 2025 он         |                |                 |
|----------------------------------------------------|-----------------|----------------|-----------------|
|                                                    | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл      | Зөрүү           |
| <b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>               | <b>8,453.2</b>  | <b>7,672.1</b> | <b>-781.1</b>   |
| <b>Татварын орлого</b>                             | <b>6,761.5</b>  | <b>5,977.7</b> | <b>-783.7</b>   |
| Орлогын албан татвар                               | 5,535.4         | 4,789.2        | -746.1          |
| Хөрөнгийн албан татвар                             | 593.8           | 609.8          | 15.9            |
| <b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>               | <b>632.3</b>    | <b>578.7</b>   | <b>-53.6</b>    |
| Бусад нийтлэг төлбөр, хураамж                      | 159.9           | 182.0          | 22.1            |
| Газрын төлбөр                                      | 313.8           | 237.2          | -76.6           |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр                    | 118.2           | 120.5          | 2.3             |
| Бусад татвар                                       | 40.3            | 38.9           | -1.4            |
| <b>Татварын бус орлого</b>                         | <b>1,691.7</b>  | <b>1,694.4</b> | <b>2.7</b>      |
| Нийтлэг татварын бус орлого                        | 977.8           | 989.3          | 11.4            |
| Хөрөнгийн орлого                                   | 9.0             | 9.9            | 1               |
| Тусламжийн орлого                                  | 15.3            | 10.3           | -5.0            |
| Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 689.6           | 684.9          | -4.7            |
| <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>           | <b>10,721.1</b> | <b>8,172.5</b> | <b>-2,548.6</b> |
| <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                               | <b>5,764.1</b>  | <b>4,781.8</b> | <b>-982.3</b>   |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                    | 2,942.5         | 2,543.5        | -398.9          |
| ХҮҮ                                                | 340.8           | 339.3          | -1.5            |
| ТАТААС                                             | 430.4           | 425.9          | -4.5            |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                   | 2,050.4         | 1,473.1        | -577.3          |
| <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                            | <b>4,846.2</b>  | <b>3,314.2</b> | <b>-1,532.1</b> |
| <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>  | <b>110.8</b>    | <b>76.5</b>    | <b>-34.3</b>    |
| <b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>                  | <b>-2,267.9</b> | <b>-500.3</b>  | <b>1,767.5</b>  |
| АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                   | 2,267.9         | 500.3          | -1,767.5        |

Орон нутгийн нийт зарлага, санхүүжилтийн 58.5 хувь буюу 4,781.8 тэрбум төгрөгийг урсгал зардалд, үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 828.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгийн зардлын гүйцэтгэл

3,314.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 1,532.1 тэрбум төгрөгөөр дутуу биелэлттэй байна.

Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 273.3 тэрбум төгрөгийн, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрээс 411.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, Орон нутгийн төсвөөс улсын төсөвт 1,290.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Булган аймаг 0.5 тэрбум төгрөг, Дорноговь аймаг 1.0 тэрбум төгрөг, Дорнод аймаг 3.0 тэрбум төгрөг, Дундговь 1.3 тэрбум төгрөг, Сэлэнгэ аймаг 8.7 тэрбум төгрөг, Төв аймаг 2.4 тэрбум, Дархан-Уул 6.8 тэрбум, Улаанбаатар 130.8 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн бол Өмнөговь, Орхон аймаг нийт 503.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт дутуу төвлөрүүлжээ.

Орон нутгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлээр нийт 7,672.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөсөн дүнгээс 9.2 хувь буюу 781.1 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна. Харин нийт зарлага 8,172.5 тэрбум төгрөгт хүрснээр төлөвлөсөн дүнгээс 23.8 хувь буюу 2,548.6 тэрбум төгрөгөөр дутуу зарлагын гүйцэтгэл гарсан байна.

## 8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 33.4 их наяд төгрөг, нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 41.8 хувьтай тэнцэж байсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 35.4 их наяд төгрөг, нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 39.4 хувьтай тэнцэж байна.

### Хүснэгт 42. Засгийн газрын өр, 2020-2025 он /тэрбум төгрөг/

| ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ                                        | 2020            | 2021            | 2022            | 2023            | 2024             | 2025             |
|--------------------------------------------------------------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|------------------|------------------|
| <b>1. Засгийн газрын дотоод өр</b>                                 | <b>1,136.6</b>  | <b>657.3</b>    | <b>1,035.5</b>  | <b>234.1</b>    | <b>400.5</b>     | <b>688.5</b>     |
| 1.1. Үнэт цаас                                                     | 1,136.6         | 657.3           | 1,035.5         | 234.1           | 400.5            | 688.5            |
| <b>2. Засгийн газрын гадаад өр</b>                                 | <b>24,851.4</b> | <b>24,693.3</b> | <b>29,641.6</b> | <b>30,274.6</b> | <b>30,296.7</b>  | <b>32,040.5</b>  |
| 2.1. Үнэт цаас                                                     | 8,354.0         | 8,175.6         | 9,359.8         | 9,371.7         | 8,655.0          | 8,964.7          |
| 2.2. Зээл                                                          | 16,497.4        | 16,517.7        | 20,281.8        | 20,902.9        | 21,641.6         | 23,075.8         |
| <b>3. Бусад өр төлбөр</b>                                          | <b>1,910.6</b>  | <b>1,567.6</b>  | <b>1,287.7</b>  | <b>264.8</b>    | <b>2,702.7</b>   | <b>2,678.6</b>   |
| 3.1. Засгийн газрын өрийн баталгаа                                 | 1,060.4         | 876.5           | 811.8           | 29.5            | 178.0            | 165.7            |
| 3.2. Орон нутгийн өр                                               |                 | 17.2            | 12.3            | 4.5             | 2,524.7          | 2,512.9          |
| 3.2.1 Дотоод өр                                                    |                 | 17.2            | 12.3            | 4.5             | 799.9            | 684.8            |
| 3.2.2 Гадаад өр                                                    |                 |                 |                 |                 | 1,727.4          | 1,828.1          |
| 3.3. Концесс ("барих-шилжүүлэх")*                                  | 850.2           | 673.9           | 463.5           | 230.9           |                  |                  |
| <b>ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (1+2+3)</b>                              | <b>27,898.6</b> | <b>26,918.1</b> | <b>31,964.8</b> | <b>30,773.5</b> | <b>33,399.9</b>  | <b>35,407.6</b>  |
| <b>ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)</b>                                     | <b>23,024.3</b> | <b>21,837.3</b> | <b>27,690.6</b> | <b>26,582.9</b> |                  |                  |
| Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар** | 70.0% (ӨҮЦ)     | 70.0% (ӨҮЦ)     | 70.0% (ӨҮЦ)     | 65.0% (ӨҮЦ)     | 60.0% (Нэрлэсэн) | 60.0% (Нэрлэсэн) |
| Засгийн газрын өр / ДНБ                                            | 75.5%           | 62.6%           | 60.5%           | 43.7%           | 41.8%            | 39.4%            |
| Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ                                      | 62.3%           | 50.8%           | 52.4%           | 37.7%           |                  |                  |

\* Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өрийн удирдлагын тухай хуулийн 40.7 дэх хэсэг хүчингүй болсон.

\*\* УИХ-аас Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлдэг байсныг нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл болгож өөрчилсөн.

Засгийн газрын өрийн багцын 95.7 хувийг Засгийн газрын болон орон нутгийн гадаад үнэт цаас, зээл, 3.9 хувийг Засгийн газрын болон орон нутгийн дотоод үнэт цаас, 0.4 хувийг Засгийн газрын өрийн баталгаа тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд өрийн зохицуулалтаас бусад Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт нийт 2,676.9 тэрбум төгрөгийг төлснөөс үндсэн төлбөрт 1,411.9 тэрбум төгрөг, хүү болон шимтгэлийн төлбөрт нийт 1,249.9 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

### Хүснэгт 43. Засгийн газрын өрийн үйлчилгээ, 2025 он /тэрбум төгрөг/

| №   | Засгийн газрын өрийн үйлчилгээ                                      | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|-----|---------------------------------------------------------------------|------------|-----------|
| 1   | 2025 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан үндсэн төлбөр | 1,701.8    | 1,527.4   |
| 1.1 | Гадаад зээл                                                         | 1,476.9    | 1,411.9   |


|     |                                                                                |                       |         |
|-----|--------------------------------------------------------------------------------|-----------------------|---------|
| 1.2 | Дотоод үнэт цаас                                                               | 110.0                 | 0.0     |
| 1.3 | Орон нутгийн үнэт цаас                                                         | 114.9                 | 115.5   |
| 2   | Гадаад үнэт цаасны өрийн зохицуулалт болон 2025 онд гаргасан зээллэгийн төлбөр | Өрийн зохицуулалт     | 1,746.5 |
| 2.1 | Номад бонд                                                                     | Өрийн зохицуулалт     | 1,356.6 |
| 2.2 | Сенчири-2 бонд                                                                 | Өрийн зохицуулалт     | 374.9   |
| 2.3 | 2025 онд гаргасан дотоод үнэт цаас                                             | Тухайн ондоо гаргасан | 15.0    |
| 3   | Хүүгийн төлбөр                                                                 | 1,292.9               | 1,249.9 |
| 3.1 | Гадаад зээл                                                                    | 615.1                 | 589.1   |
| 3.2 | Гадаад үнэт цаас                                                               | 632.6                 | 625.3   |
| 3.3 | Дотоод үнэт цаас                                                               | 45.2                  | 35.5    |
| 4   | Өрийн зохицуулалтаас бусад нийт төлбөр                                         | 2,994.7               | 2,777.3 |

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн Зорилт 2-т “Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.” гэж заасан. Үүний дагуу гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал, эрсдэлийн судалгааг тогтмол хийсний үндсэн дээр 6.625 хувийн хүүтэй 500 сая ам долларын “Сенчири-4” бондыг 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр олон улсын зах зээлд арилжаалж “Номад” бондоос 391.7 сая ам доллар буюу 1,356.6 тэрбум төгрөг, “Сенчири-2” бондоос 108.3 сая ам доллар буюу 374.9 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг дахин санхүүжүүлсэн.

## ДОТООД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын дотоод үнэт цаас /ЗГДҮЦ/-ны үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 400.5 тэрбум төгрөг байсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 688.5 тэрбум төгрөг болж, 288.0 тэрбум төгрөгөөр өссөн.

**Зураг 28. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл, 2025 он / тэрбум төгрөг/**



Засгийн газраас 2025 онд Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн дэмжих зорилгоор Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 148.7 тэрбум төгрөгийн үнэт цаасыг нээлттэй хэлбэрээр, төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор 150.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хаалттай хэлбэрээр тус тус арилжаалсан.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн 4 дүгээр зорилтод “Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна.” гэж заасан. Энэ хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс Монголын хөрөнгийн биржийн арилжааны системээр дамжуулан ЗГДҮЦ-ны нээлттэй арилжааг эхлүүлсэн. Энэ нь ЗГДҮЦ-ны зах зээлийг хөгжүүлэх, эрсдэлгүй хөрөнгө оруулалтын өгөөжийн муруйг тогтоох ач холбогдолтой бөгөөд ЗГДҮЦ-ны арилжааг 2 долоо хоног тутам олон нийтэд нээлттэйгээр тогтмол арилжаалж байна.

Нээлттэй хэлбэрээр арилжаалсан үнэт цаасны 41.0 хувийг 1 жил хүртэлх богино хугацаат үнэт цаас, 56.5 хувийг 2-5 жилийн дунд хугацаат үнэт цаас, 2.5 хувийг 7 жилийн урт хугацаат үнэт цаас тус тус эзэлж байна. Түүнчлэн ЗГДҮЦ-ны богино хугацаат үнэт цаасны дундаж хүү 9.3 хувь, дунд хугацаат үнэт цаасны дундаж хүү 10.8 хувь, урт хугацаат үнэт цаасны дундаж хүү 13.3 хувь байна. Тайлант жилд нийт 32 удаагийн нээлттэй арилжааг зохион байгуулснаас давхардсан тоогоор 237 хөрөнгө оруулагч оролцож 425 саналыг ирүүлсэн. ЗГДҮЦ-ны 71.7 хувийг арилжааны банк, 9.9 хувийг даатгалын байгууллага, 18.5 хувийг гадаад дотоодын иргэд, аж ахуйн нэгж эзэмшиж байна.

**Зураг 29. Засгийн газрын дотоод үнэт цаасны өгөөжийн муруй**



Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 66.5 хувь буюу 457.9 тэрбум төгрөгийг 2024-2025 онд мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор арилжаалсан үнэт цаас, 19.4 хувь буюу 133.5 тэрбум төгрөгийг ЗГДҮЦ-ны зах зээлийг дэмжих зорилгоор арилжаалсан үнэт цаас, 14.1 хувь буюу 97.1 тэрбум төгрөгийг Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас тус тус эзэлж байна. Тайлант онд Засгийн газрын дотоод үнэт цаасны үйлчилгээний төлбөрт нийт 50.5 тэрбум төгрөг төлсөн. Үүнээс үндсэн төлбөрт 15.0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 35.5 тэрбум төлбөрийг шилжүүлсэн.



## 8.1. ГАДААД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 2,530.5 сая ам.доллар буюу 8,655.0 тэрбум төгрөг байсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 2,520.5 сая ам.доллар буюу 8,964.7 тэрбум төгрөг болон буурсан байна.

**Хүснэгт 44. Засгийн газрын гадаад үнэт цаас, 2025 он**

| №           | Гадаад үнэт цаас | Гаргасан дүн      | Гаргасан огноо | Купон  | Хугацаа | Үлдэгдэл       |                |
|-------------|------------------|-------------------|----------------|--------|---------|----------------|----------------|
|             |                  |                   |                |        |         | Сая ам.доллар  | тэрбум төгрөг  |
| 1           | Номад            | 600 сая ам.доллар | 2020.10.07     | 5.125% | 5.5 жил | 176.0          | 626.1          |
| 2           | Сенчири-1 2027   | 500 сая ам.доллар | 2021.07.07     | 3.500% | 6 жил   | 418.5          | 1,488.4        |
| 3           | Сенчири-1 2031   | 500 сая ам.доллар | 2021.07.07     | 4.450% | 10 жил  | 505.0          | 1,796.1        |
| 4           | Сенчири-2        | 650 сая ам.доллар | 2023.01.19     | 8.650% | 5 жил   | 559.8          | 1,991.1        |
| 5           | Сенчири-3        | 350 сая ам.доллар | 2023.12.05     | 7.875% | 5.5 жил | 349.8          | 1,244.1        |
| 6           | Сенчири-4        | 500 сая ам.доллар | 2025.02.25     | 6.625% | 5 жил   | 511.4          | 1,818.9        |
| <b>НИЙТ</b> |                  |                   |                |        |         | <b>2,520.5</b> | <b>8,964.7</b> |

Тайлант хугацаанд Засгийн газрын гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт нийт 1,731.5 тэрбум төгрөг төлсөн бөгөөд үүнээс хүүгийн төлбөрт 177.5 сая ам доллар буюу 625.3 тэрбум төгрөгийг, өрийн зохицуулалтын хүрээнд “Номад” бондын үндсэн төлбөрт 391.7 сая ам доллар буюу 1,356.6 тэрбум төгрөгийг, “Сенчири-2” бондын үндсэн төлбөрт 108.3 сая ам доллар буюу 374.9 тэрбум төгрөгийг төлсөн байна.

**Хүснэгт 45. Засгийн газрын гадаад үнэт цаасны өрийн үйлчилгээ, 2025 он**

| №           | Гадаад үнэт цаас | Үндсэн төлбөр |                | Хүүгийн төлбөр |               |
|-------------|------------------|---------------|----------------|----------------|---------------|
|             |                  | сая ам.доллар | тэрбум төгрөг  | сая ам.доллар  | тэрбум төгрөг |
| 1           | Номад            | 108.3         | 374.9          | 16.6           | 58.3          |
| 2           | Сенчири-1 2027`  |               |                | 21.7           | 76.5          |
| 3           | Сенчири-1 2031`  |               |                | 33.4           | 117.5         |
| 4           | Сенчири-2        | 391.7         | 1,356.6        | 52.5           | 183.6         |
| 5           | Сенчири-3        |               |                | 27.6           | 98.3          |
| 6           | Сенчири-4        |               |                | 25.7           | 91.1          |
| <b>НИЙТ</b> |                  | <b>500.0</b>  | <b>1,731.5</b> | <b>177.5</b>   | <b>625.3</b>  |

## 8.2. ГАДААД ЗЭЭЛ

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2024 оны жилийн эцэст 21,641.6 тэрбум төгрөг байсан бол 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 23,075.8 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт өрийн багцын 65.2 хувийг эзэлж байна.

**Хүснэгт 46. Засгийн газрын гадаад зээл, 2025 он /тэрбум төгрөг/**

| №           | Ангилал          | Эхний үлдэгдэл  | Нэмэгдсэн      | Хорогдсон      | Ханшийн зөрүү  | Эцсийн үлдэгдэл | Хуримтлагдсан хүү | Нэрлэсэн үлдэгдэл |
|-------------|------------------|-----------------|----------------|----------------|----------------|-----------------|-------------------|-------------------|
| 1           | Төслийн зээл     | 15,543.7        | 1,535.7        | 830.4          | 1,022.1        | 17,271.1        | 101.8             | 17,372.9          |
| 2           | Хөтөлбөрийн зээл | 5,936.5         | 5.4            | 581.5          | 296.3          | 5,656.7         | 46.2              | 5,702.9           |
| <b>Нийт</b> |                  | <b>21,480.2</b> | <b>1,541.1</b> | <b>1,411.9</b> | <b>1,318.4</b> | <b>22,927.8</b> | <b>147.9</b>      | <b>23,075.8</b>   |

Олон улсын банк санхүүгийн байгууллага, түншлэгч орнуудын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 75 төсөл, хөтөлбөрийг хүрээнд 2025 онд нийт 1,541.1 тэрбум төгрөгийг авч ашигласнаас төслийн зээлийн ашиглалтад 1,535.7 тэрбум төгрөг, хөтөлбөрийн зээлийн ашиглалтад 5.4 тэрбум төгрөгийг тус тус шинээр ашигласан байна.

Хэрэгжиж буй төслүүдийн томоохон ашиглалтуудаас дурдвал: Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-д 446.1 тэрбум төгрөг, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”-д 272.4 тэрбум төгрөг, Бүгд Найрамдах Франц Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төсөл”-д 67.0 тэрбум төгрөг, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Улаанбаатар-Дархан чиглэлийн 2 эгнээ зам барих төсөл”-д 51.7 тэрбум, Бүгд Найрамдах Солонгос Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Баянголын аманд 2007 айлын орлогод нийцсэн орон сууцны хороолол барих төсөл”-д 47.6 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газар гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж 2025 онд гадаад зээлийн үндсэн төлбөрт 1,411.9 тэрбум төгрөг, хүү, шимтгэлийн төлбөрт 589.1 тэрбум төгрөг, нийт 1,959.8 тэрбум төгрөгийг өрийн үйлчилгээний төлбөрт төлсөн.

### 8.3. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА

Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 178.0 тэрбум төгрөг байсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 165.7 тэрбум төгрөг байна.

**Хүснэгт 47. Засгийн газрын өрийн баталгаа, 2025 он**

| №    | Баталгаа гаргуулагч        | Зээлдүүлэгч           | Валют | Баталгаа гаргасан огноо | Нэрлэсэн үлдэгдэл  |               |               |
|------|----------------------------|-----------------------|-------|-------------------------|--------------------|---------------|---------------|
|      |                            |                       |       |                         | үндсэн валют /сая/ | тэрбум төгрөг | сая ам.доллар |
| 1    | Монгол Улсын Хөгжлийн банк | Хятадын хөгжлийн банк | Юань  | 2024.04.01              | 322.7              | 165.7         | 46.6          |
| Нийт |                            |                       |       |                         | 322.7              | 165.7         | 46.6          |

Тайлант хугацаанд Монгол Улсын Хөгжлийн банк нь үндсэн төлбөрт 53.8 сая юань буюу 26.8 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 18.8 сая юань буюу 9.3 тэрбум төгрөгийг төлсөн байна. Ингэснээр Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2025 онд 12.3 тэрбум төгрөгөөр буурсан.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2024 оны “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” 17 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас олон улсын зах зээлд “Сэлбэ дэд төвийн орон сууцжуулалтын төсөл”-ийг санхүүжүүлэх зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр гаргасан 500 сая ам.долларын үнэт цаасанд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д заасны дагуу аймаг, нийслэлийн өр болон Засгийн газрын өрийн баталгаа нь Засгийн газрын өрд тооцогддог тул тухайн үнэт цаасны үлдэгдлийг Засгийн газрын өрийн нэгтгэлд орон нутгийн өр хэсэгт тайлагнасан болно.

#### 8.4. ОРОН НУТГИЙН ЗЭЭЛЛЭГ

Засгийн газрын 2024 оны 201 дүгээр тогтоол, Засгийн газрын 2025 оны 264 дүгээр тогтоол болон Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд нийт 798.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасыг “Бөөрөлжүүтийн ДЦС-ыг барих төсөл”, “Батарей хуримтлуурын төсөл” болон Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлийн ажлын төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан бол 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаасыг “Сэлбэ дэд төв”-ийн бүтээн байгуулалтад зориулж гаргасан байна.

Орон нутгийн зээллэгийн үлдэгдэл 2024 онд 2,524.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 2,512.9 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Тайлант хугацаанд нийт 115.5 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлсөн бөгөөд үүнээс Улаанбаатар хотын авто, замын байгууламжийн засвар, шинэчлэлийн ажлын төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цааснаас 100.0 тэрбум төгрөгийг, Батарей хуримтлуурын станц барих зорилгоор арилжаалсан үнэт цааснаас 15.5 тэрбум төгрөгийг төлсөн байна.

**Хүснэгт 48. Орон нутгийн зээллэг, 2025 он**

| № | Үнэт цаас гаргагч                    | Зориулалт                        | Гаргасан огноо | Эргэн төлөх огноо | Нэрлэсэн үлдэгдэл<br>Тэрбум төгрөг |
|---|--------------------------------------|----------------------------------|----------------|-------------------|------------------------------------|
| 1 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Зам засвар, арчилгаа             | 2024.06.25     | 2025.06.25        | 100.3                              |
| 3 |                                      | Бөөрөлжүүтийн ДЦС барих          | 2024.06.25     | 2027.06.25        | 300.8                              |
| 4 |                                      | Батарей хуримтлуурын станц барих | 2024.12.26     | 2029.12.26        | 283.7                              |
| 5 |                                      | Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах | 2024.11.29     | 2027.08.29        | 1,828.1                            |
|   | НИЙТ                                 |                                  |                |                   | 2,512.9                            |

## 8.5. ДАМЖУУЛАН ЗЭЭЛ

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос эхлэн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүнээр элсэн орж олон талт болон хоёр талт зээлдүүлэгчдээс хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, тусламж, техник туслалцааг авч ашиглаж ирсэн ба 1991-2025 он хүртэлх хугацаанд нийт 9.5 тэрбум ам.долларын гадаад зээлийг авч ашигласнаас 2.5 тэрбум ам.долларыг дотоодын аж ахуйн нэгж, байгууллагад дамжуулан зээлдүүлсэн байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 3,776.9 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 401.4 тэрбум төгрөгийг нэмж олгон, зээлийн эргэн төлөлтөд нийт 368.3 тэрбум төгрөгийн /үүнээс үндсэн төлбөрт 285.3 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 83.0 тэрбум төгрөг/ орлогыг төсөвт төвлөрүүлж 2025 оны жилийн эцсийн байдлаар дамжуулан зээлийн үлдэгдэл 4,088.0 тэрбум төгрөг байна.

Тайлант хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларснаас шалтгаалан дамжуулан зээлийн үлдэгдэлд 182.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэх шалтгаан болсон байна.

**Хүснэгт 49. Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/**

| Ангилал                                                | Эхний үлдэгдэл | Нэмэгдсэн    | Хорогдсон    | Ханшийн зөрүү  | Эцсийн үлдэгдэл |
|--------------------------------------------------------|----------------|--------------|--------------|----------------|-----------------|
| Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон | 1,982.4        | 402.9        | 388.9        | 84.7           | 2,081.0         |
| Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл           | 1,464.3        | 267.2        | 150.5        | 66.4           | 1,647.5         |
| Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл           | 330.2          |              | 2.1          | 31.3           | 359.5           |
| <b>НИЙТ</b>                                            | <b>3,776.9</b> | <b>670.1</b> | <b>541.5</b> | <b>(182.4)</b> | <b>4,088.0</b>  |

**Хүснэгт 50. Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл /салбараар/**

| №  | Салбар                         | 2019         | 2020         | 2021         | 2022         | 2023         | 2024         | 2025        |
|----|--------------------------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|-------------|
| 1  | Жижиг дунд үйлдвэрлэл          | 140          | 204          | 177          | 179          | 161          | 138          | 139         |
| 2  | Зам, тээврийн салбар           | 466          | 513          | 580          | 656          | 632          | 552          | 591         |
| 3  | Нийгмийн халамжийн салбар      | 26           | 11           | 11           | 12           | 3            | 12           | 10          |
| 4  | ОСНААҮ-ий салбар               | 639          | 810          | 844          | 980          | 1,007        | 1,020        | 1062        |
| 5  | Санхүү, эдийн засгийн салбар   | 199          | 201          | 169          | 227          | 258          | 272          | 304         |
| 6  | Хувийн хэвшлийн хуулийн этгээд | 300          | 328          | 321          | 374          | 377          | 342          | 372         |
| 7  | Уул уурхайн салбар             | 102          | 90           | 121          | 119          | 111          | 97           | -           |
| 8  | Харилцаа холбооны салбар       | 74           | 59           | 55           | 55           | 52           | 48           | 47          |
| 9  | Хөдөө аж ахуйн салбар          | 261          | 264          | 311          | 325          | 309          | 295          | 271         |
| 10 | Эрчим хүчний салбар            | 456          | 508          | 519          | 649          | 796          | 1,002        | 1291        |
|    | <b>НИЙТ</b>                    | <b>2,663</b> | <b>2,988</b> | <b>3,106</b> | <b>3,576</b> | <b>3,706</b> | <b>3,777</b> | <b>4088</b> |

**Эргэн төлөлтийн талаар:**

**Хүснэгт 51. Дамжуулан зээлийн гэрээний дагуу төлбөрөө 2025 онд бүрэн төлж дууссан зээлүүд**

| Дугаар         | Донор | Эцсийн зээлдэгч                         | Валют | Гэрээ байгуулсан он | Гэрээний дүн     |
|----------------|-------|-----------------------------------------|-------|---------------------|------------------|
| OL-3659MOG-1   | ДБ    | Монгол банк                             | USD   | 2003-05-08          | 3,901,609.0      |
| OL-4088MOG-12  | ДБ    | ХХБанк                                  | USD   | 2006-01-20          | 287,305.0        |
| OL-2947MOG     | ДБ    | Дархан-Уул аймгийн Төмөрлөгийн үйлдвэр  | MNT   | 1997-07-31          | 6,823,434.7      |
| OL-2301MON-08  | АХБ   | Нийслэлийн ЗДТГ газар                   | MNT   | 2008-12-10          | 10,037,330,871.8 |
| OL-1847MON-08  | АХБ   | Баянхонгор аймгийн ЗДТГ                 | MNT   | 2002-01-01          | 256,056,370.0    |
| OL-1907MON-07  | АХБ   | Булган аймгийн ЗДТГ                     | MNT   | 2004-11-08          | 1,727,686,618.0  |
| OL-1847MON-03  | АХБ   | Говь-Алтай аймгийн ЗДТГ                 | MNT   | 2002-01-01          | 464,880,911.1    |
| OL-3244MON(SF) | АХБ   | Дархан-Уул аймгийн ЗДТГ                 | USD   | 2016-02-15          | 9,450,000.0      |
| OL-3245MON(SF) | АХБ   | Дархан-Уул аймгийн ЗДТГ                 | SDR   | 2015-06-05          | 6,159,000.0      |
| OL-FR001-MNT   | Франц | Орхон аймгийн ЗДТГ                      | MNT   | 2009-07-02          | 9,535,000.0      |
| OL-1907MON-04  | АХБ   | Өмнөговь аймгийн ЗДТГ                   | MNT   | 2004-11-08          | 1,102,213,269.7  |
| OL-1992-03     | Хятад | Санхүү, эдийн засгийн яам               | MNT   | 2003-06-30          | 21,277,300.0     |
| OL-3503MOG-04  | ДБ    | Дорнод бүсийн ЭХС ТӨХК Сүхбаатар салбар | MNT   | 2004-04-21          | 685,304,866.6    |
| OL-MON-P2-MNT  | Япон  | УБ Төмөр Зам ХНН                        | MNT   | 2000-01-01          | 4,585,363,646.0  |
| OL-MON-P5-2    | Япон  | ЦДҮС ТӨХК                               | MNT   | 2012-01-01          | 2,397,117,000.0  |

---oOo---